

БИД БОНУ-НИЙ ТАЙЛАН
ХЭЛЭЛЦЭХ ХУРАЛДАА
ИДЭВХТЭЙ
ОРОЛЦОНО



**БАЙГАЛЬ ОРЧНЫ
НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭ
БА ТАЛУУДЫН ОРОЛЦОО**

ГАРЫН АВЛАГА







**БАЙГАЛЬ ОРЧНЫ
НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭ
БА ТАЛУУДЫН ОРОЛЦОО**

ГАРЫН АВЛАГА

Улаанбаатар хот
2022 он

МЭДЭГДЭЛ

Энэхүү тайлан, илтгэлийг Австрали Улсын Засгийн газар, Австралийн Гадаад хэрэг, худалдааны яам санхүүжүүлсэн боловч тус тайланд тусгасан үзэл санаа нь Австрали Улсын Засгийн газар бус гагцхүү зохиогчийн үзэл бодол болно. Мөн түүнчлэн энэ тайланд тусгасан үзэл баримтлалыг Австрали Улсын Засгийн газар дэмжиж байгаа гэж ойлгож болохгүй. Тус улсын Засгийн газар энэ тайланд багтсан мэдээллийн бүрэн болон үнэн зөв эсэхийг батлахгүй. Энэхүү хэвлэлд орсон тоо баримт, мэдээ материал алдаа мадагтай, дутуу хагас байж болзошгүй бөгөөд түүнээс үүдэн гарах аливаа хохиролд Австрали Улсын Засгийн газар, хариуцлагатай албан тушаалтан, ажилтан, албан хаагч, гэрээт ажилчид ямар нэг хариуцлага хүлээхгүй болно. Энэхүү тайлан нь ерөнхий мэдээлэл өгөх зорилготой. Аливаа шийдвэр гаргахаас өмнө тайланг уншиж, хэрэглэж буй тал мэдээллийн анхдагч эх сурвалжтай холбогдон, мэдээ баримтаа лавшруулан шалгаж, бие даасан судалгаа хийн, зөвлөгөө авах нь зүйтэй.

ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛЭГЧ

АМЕП 2 хөтөлбөрийг Австралийн Гадаад хэрэг, худалдааны яам (Австралийн тусламжийн хөтөлбөр) санхүүжүүлж, Адам Смит Интернэйшнл зөвлөх компани хэрэгжүүллээ.

Adam Smith
International

“Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ ба талуудын оролцоо” гарын авлагыг Байгаль орчин, аялал жуулчлалын яамны санаачилга, Австрали Монголын Эрдэс баялгийн салбарын хамтын ажиллагааны хөтөлбөр (АМЕП 2) -ийн дэмжлэгтэйгээр Монголын Тогтвортой Хөгжил, Нийгмийн Хариуцлагын Зөвлөл ТББ гүйцэтгэв.

ЗОХИОГЧИД:

Б.Баяржаргал
Ж.Чанцалдулам
О.Батболд

Редатор: Н.Ариунтуяа

Хавтас болон номын зураг: Б.Мартин, П.Пүүдорж

Эх бэлтгэл: Б.Мөнхболор

Хэвлэсэн: 2022 он, Улаанбаатар хот.

© **Тогтвортой хөгжил**
Нийгмийн хариуцлагын зөвлөл

ТАЛАРХАЛ

Энэхүү гарын авлагыг бүтээхэд тусалсан байгууллага, хүн болгонд, хамтран ажилласан багийн гишүүддээ гүнээ талархаж байна.

Төслийг санаачилж, дэмжсэн, удирдамжаар хангаж, тасралтгүй хувь нэмрээ оруулж ажилласан Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Австрали Монголын Эрдэс баялгийн салбарын хамтын ажиллагааны хөтөлбөр (АМЕП 2) -ийн хамт олонд чин сэтгэлийн талархлаа илэрхийлье.



Гарын авлагын тухай

Монгол Улсын Засгийн газар, Австрали Улсын Засгийн газрын хамтран хэрэгжүүлж буй Австрали-Монголын эрдэс баялгийн салбарын хамтын ажиллагааны хөтөлбөр /АМЕП-2/-өөс Байгаль орчин, аялал жуулчлалын яам /БОАЖЯ/-ны захиалгаар “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд /БОНБУ/ олон нийтийн оролцоог хангахад дэмжих” төслийг хэрэгжүүлж байна.

Энэхүү төсөл нь Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ (БОНБУ)-нд олон нийтийн оролцоог хангах, мэдээллийг ил тод нээлттэй болгох, мэдэх эрхийг хангах ажилд гарч буй хүндрэл, оролцогч талуудын хооронд үүсээд буй зөрчлийг арилгахын тулд олон талт оролцоог хангах, хариуцсан салбарын төрийн захиргааны байгууллага, мэргэжлийн байгууллага, мэргэжилтэн, орон нутгийн удирдлага, иргэдийг чадавхжуулах, мэдээллээр хангах зорилготой юм.

Уг төслийн хүрээнд “Монголын Тогтвортой хөгжил, нийгмийн хариуцлагын зөвлөл” ТББ нь холбогдох талуудад зориулж “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ ба талуудын оролцоо” гарын авлага-зөвлөмж болон цахим сургалтын модуль

боловсруулан олон нийтэд хүргэж байна.

“Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ ба талуудын оролцоо” гарын авлага-зөвлөмжийг ашигласнаар та бүхэн Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд хувь нэмрээ оруулах, иргэд, орон нутгийн байгууллагууд олон нийтийн оролцооны ач холбогдлыг ойлгож, баг, хорооны Иргэдийн Нийтийн Хурлын үр ашгийг дээшлүүлэх, иргэд оролцоогоо хангах, мэдэх эрхээ хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэхэд ахиц гаргах зорилготой болно.

ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах журмыг Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны 1 дүгээр сарын 06-ны өдрийн А-03 тушаалаар баталсан байдаг. Тус журмын дагуу үнэлгээний төрлөөс хамаарч олон нийтийн оролцоог харилцан адилгүйгээр хангах, тухайн оролцоог хангах ажлыг хариуцах байгууллага, арга хэлбэр зэргийг зохицуулсан байдаг.

Хэдий тийм боловч тухайн журмыг хэрэгжүүлэхэд алдаа дутагдал гарсаар байгаа нь АМЕП-2 төслийн¹ хүрээнд хийгдсэн судалгааны дүнд харагдаж байна. Тухайлбал, ИНХ-д танилцуулж тогтоол, тэмдэглэл авах хуулийн болон журмын хугацааны ялгаатай байдлаас шалтгаалж зарим БОНБУ-д ИТХ-ын тогтоол, тэмдэглэл авсан, олон нийтийн оролцоог хангасан тухай баримт бичиг 2021 оноос эхэлж мэдээллийн санд орж байгаа, орон нутгийн удирдлага үнэлгээний тайлангийн нэг хувийг хүлээж авсан ч иргэд танилцах боломжийг хангаагүй, БОНБУ-ний тайлан нь иргэдэд уншиж ойлгоход хүндрэлтэй байдлаар боловсруулагдсан, иргэдэд зориулсан техникийн бус хураангуй байхгүй гэх мэт асуудлууд байсаар байна.

Нөгөө талдаа үнэлгээний эрх бүхий аж ахуйн нэгжүүдийн олон нийтийн оролцоог хангах тухай ойлголт харилцан адилгүй байгаагаас тухайн төслийн БОНБУ боловсруулах явцад харилцан адилгүйгээр иргэдийн оролцоог хангадаг байна.² Мөн БОНБУ-ний тайланг ИНХ-аар хэлэлцүүлэхэд хуулийн хугацаа, журмаар зохицуулсан зохицуулалт зөрчилдөх, ээлжит бус ИНХ зарлаж, тайлангаа танилцуулах боломж хомс, иргэдэд мэдээлэл өгөх, санал авах ажлын тухай орон нутгийн удирдлага, иргэд ойлголтгүй байгаагаас зөвхөн тухайн төсөлд зөвшөөрөл өгөх гэж байгаа мэт ойлгож буй, иргэдийн оролцоо сул, БОАЖА-ны зүгээс бодлого, арга зүйн дэмжлэг сул, хууль, журам, аргачлалын талаар орон нутагт мэдээлэл, сургалт хийдэггүй зэргээс шалтгаалж олон нийтийн оролцоог

хангах ажлын үр дүнд сөрөг үр дагавар гарч байна.³ Мөн төсөл хэрэгжүүлэгчийн зүгээс тухайн тайланд өгсөн санал хэрхэн туссан, хэрхэн байгаль орчны менежментийн төлөвлөгөөгөө хэрэгжүүлж буй талаар мэдээллийг хангалттай өгдөггүйтэй холбоотой иргэдийн зүгээс таагүй хандлага гаргах нь нэмэгдэж байна.⁴

Дэлхийн байгаль хамгаалах сангийн хийсэн судалгаагаар Увс аймгийн Бөхмөрөн суманд хийсэн судалгаанд оролцогсодын 96.9% нь БОННУ-ний талаар мэдлэг, мэдээлэл хомс, уул уурхайн байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд саналаа өгсөн нь 2.2%-тай байсан байна. Мөн тэдгээр иргэдийн өгсөн санал БОННУ-ний тайланд орсон эсэх талаар мэдээлэл байдаггүй, эргэж мэдэгддэггүй зэрэг асуудлууд гардаг байна. Түүнчлэн орон нутагт иргэдэд мэдээлэл хүрдэг гол мэдээллийн суваг нь хурал, цуглаан байдаг. Гэвч хурлын мэдээлэл хангалттай урьдчилж хүрдэггүй учир иргэд тэр бүр уул уурхайн талаар мэдээлэл сайн авч чаддаггүй, мэдээллийн ил тод, нээлттэй байдал болон үнэн зөв мэдээлэл түгээх нөхцөл байдал хязгаарлагдмал байдаг байна.⁵

ИНХ-аар БОНБУ-ний тайланг хэлэлцсэн тэмдэглэлд хийсэн дүн шинжилгээгээр нийт санал, асуулгын 71.2% нь төсөл хэрэгжүүлэгчтэй хамтарч ажиллах тухай, үлдэх 29.8% нь байгаль орчны холбогдолтой асуудлууд байгаа нь ИНХ болон орон нутгийн иргэд, удирдлагад тухайн олон нийтийн оролцоог хангахтай холбоотой мэдлэг, мэдээлэл хязгаарлагдмал байгааг илтгэж байна. Мөн ИНХ-ын тогтоол нь төслийн үйл ажиллагааг дэмжсэн тухай утгатай⁶ байгаа нь бүх түвшинд БОНБУ-ний тайланд олон нийтийн оролцоог хангах тухай мэдлэг, мэдээлэл хангалтгүй, зөрүүтэй байгааг давхар илтгэж байна. Энэхүү асуудлын гол шалтгаан нь хууль, журмын ойлгомжгүй байдал, олон нийтийн оролцоог хангах арга хэлбэрүүд хэт хязгаарлагдмал байгаа, хууль, журмын хооронд үүсдэг зөрчил, мөн албан тушаалтнуудын хүнд суртал зэрэгтэй холбоотой талаар мэргэжлийн байгууллагууд санал нэгтэй байна.⁷

¹АМЕП-2 төсөл. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах журам, түүний хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээ, 2021 он.

²АМЕП-2 төсөл. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах нь: Оролцогч талуудын судалгаа, 2021 он.

³Дэлхийн байгаль хамгаалах сангийн (WWF) Монгол дахь хөтөлбөрийн газар, 2017 он. Уул уурхайн шийдвэр гаргалтад талууд оролцох нөхцөл, боломж. Үнэлгээний тайлан.

⁴АМЕП-2 төсөл. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах нь: Оролцогч талуудын судалгаа, 2021 он.

⁵Дэлхийн байгаль хамгаалах сангийн (WWF) Монгол дахь хөтөлбөрийн газар, 2017 он. Уул уурхайн шийдвэр гаргалтад талууд оролцох нөхцөл, боломж. Үнэлгээний тайлан.

⁶АМЕП-2 төсөл. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах нь: Иргэдийн Нийтийн Хурлын санал, тэмдэглэлд хийсэн дүн шинжилгээ, 2021 он.

⁷Б.Баяржаргал, С.Түмэннаст, Ш.Анармаа, Д.Өлзийбаяр. КОВИД-19 ба Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ: Асуумж судалгааны тайлан, 2021 он.

БҮЛЭГ 1. БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТУХАЙ	13
1.1. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тогтолцоо	14
1.2. Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний үе, шатууд	14
1.2.1. Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ	15
1.2.2. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ	15
1.2.3. Уул уурхайн нарийвчилсан мөчлөг	17
 БҮЛЭГ 2. БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭНД ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦООГ ХАНГАХ ХУУЛЬ ЭРХЗҮЙН ОРЧИН	 21
2.1. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах журам	24
 БҮЛЭГ 3. БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭНД ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦООГ ХАНГАХ НЬ	 27
3.1. Олон нийтийн оролцоог хангахад талуудын эрх, үүрэг	28
Байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд олон нийтийг оролцуулсан сайн туршлага	32
3.1.1. Оролцогч талуудын тэгш, хүртээмжтэй байдлыг хангах	37
Оролцогч талуудын зураглал	38

АГУУЛГА

Оролцогч талуудын матриц	39
3.2. Олон нийтийн оролцоог хангах үе шатууд	41
3.3. Олон нийтийн хэлэлцүүлэг хийх шийдвэр гаргах	42
3.3.1. Олон нийтэд хэлэлцүүлгийн тухай мэдээлэл түгээх	43
3.4. Иргэдийн Нийтийн Хурал зохион байгуулах	46
3.4.1. БОННУ-ний тайланг олон нийтэд нээлттэй болгох	52
БҮЛЭГ 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭ БА МЭДЭХ ЭРХ	55
4.1.1 Байгаль орчныг хамгаалах тухай хууль	55
4.1.2 Байгаль орчинд нөлөөлөх байдлын тухай хууль	56
4.1.3 Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль	58
5. ХАВСРАЛТУУД	61
5.1 Мэдээлэл цуглуулах, хянах үнэлэх аргууд	61
5.2 Шалгах хуудас: ИНХ-ын хэлэлцүүлэг	14
5.3 Шалгах хуудас: Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний хэлэлцүүлэг	64
	65



БҮЛЭГ 1 . БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТУХАЙ

“Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ” гэдэг нь аливаа төлөвлөж буй үйл ажиллагаа, төслийн байгаль орчинд үзүүлж болзошгүй эерэг болон сөрөг нөлөөллийг шинжлэх ухааны үндэслэлтэй тогтоох, таамаглах, үнэлэх системчилсэн үйл явц юм.

Монгол Улсын Их Хурлаас 2012 онд баталсан Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай /шинэчилсэн найруулга/ хуульд “Байгаль орчны үнэлгээ” гэж иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас тодорхой төслийг хэрэгжүүлэх явцад байгаль орчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл, үр дагаврыг урьдчилан тодорхойлж, түүнийг бууруулах, арилгах арга хэмжээ тогтоохыг хэлнэ” хэмээн заасан байдаг.



ТА МЭДЭХ ҮҮ?

Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ (БОНУ) нь Америкийн Нэгдсэн Улсаас үүсэлтэй. Үндэсний байгаль орчны бодлогын акт хэмээх хуулийг 1969 онд баталснаар АНУ-д аливаа төслийг хэрэгжүүлж эхлэхээс өмнө байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тайлан шаардаж эхэлсэн байдаг. Улмаар БОНУ нь дэлхийн олон улсад хуульчлагдаж эхэлжээ. Тухайлбал, Австрали (1974), Нидерланд (1974), БНХАУ (1979), Япон (1984) болон Европын холбооны улсууд (1985) албан ёсоор хуульчлан, хэрэгжилтийг хангаж эхэлсэн байна.

1.1. БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТОГТОЛЦОО

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ гэдэгт:

- i. Стратегийн нөлөөллийн үнэлгээ,**
- ii. Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ,**
- iii. Байгаль орчны төлөв байдлын үнэлгээ,**
- iv. Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ** хамаардаг.

Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ болон байгаль орчны төлөв байдлын үнэлгээг иргэн, аж ахуйн нэгж, төрийн байгууллагаас хэрэгжүүлэх төслүүдэд зориулан гүйцэтгэх бол стратегийн болон хуримтлагдах нөлөөллийн үнэлгээг томоохон хэмжээний бодлого, стратеги төлөвлөгөө, төсөл хөтөлбөрийг

хэрэгжүүлэхээс өмнө байгаль орчин, нийгмийн нөлөөллийг тодорхойлох үүднээс гүйцэтгэнэ. Эдгээр үнэлгээг тухайн бодлого, хөтөлбөрийг хариуцсан төрийн захиргааны байгууллага мэргэжлийн байгууллагын тусламжтай боловсруулж, байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж, хянуулах үүрэгтэй байдаг. Байгаль орчны төлөв байдлын үнэлгээ, Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ болон Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг зөвхөн БОАЖЯ-наас зөвшөөрөл авсан эрх бүхий мэргэжлийн байгууллага боловсруулна.

1.2. БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ҮЕ, ШАТУУД

Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ гэдэгт:

- (i) байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ**
- (ii) байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг** хамруулан ойлгоно.

Тухайн үнэлгээнүүд өөр өөрийн ялгарах онцлогтой. Мөн гүйцэтгэх байгууллагын хувьд ялгаатай. Үүний талаар хойно товч мэдээлэл өгье.



1.2.1. БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛЛИЙН ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭ

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн **7.3** дугаар зүйлийн дагуу Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээг аймаг, нийслэлийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар эсвэл Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага (БОАЖЯ) тухайн төслийн техник-эдийн засгийн үнэлгээ (ТЭЗҮ), зураг төсөл, газрын гэрчилгээ, байгаль орчны төлөв байдлын үнэлгээний тайлан зэрэгт үндэслэн гүйцэтгэдэг. Тус хуулийн **7.4** дүгээр зүйлийн дагуу дээрх үнэлгээг хийснээр тухайн төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай байгаль орчны холбогдолтой анхан шатны шийдвэрийг дараах байдлаар гаргадаг.

1. **7.4.1.** техник, технологи, үйл ажиллагаа нь байгаль орчинд халтай, газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй, стратегийн үнэлгээний дүгнэлт болон холбогдох хууль тогтоомжид нийцээгүй төслийг хэрэгжүүлэхээс татгалзах, эсхүл буцаах;
2. **7.4.2.** төслийг байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийлгэлгүйгээр тодорхой нөхцөл, болзолтойгоор хэрэгжүүлэх боломжтой гэж үзэх;
3. **7.4.3.** байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийлгэх шаардлагатай гэж үзэх.



1.2.2. БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛЛИЙН НАРИЙВЧИЛСАН ҮНЭЛГЭЭ

Тус үнэлгээг төсөл хэрэгжүүлэгчийн захиалгаар байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх эрх бүхий мэргэжлийн байгууллагууд гүйцэтгэнэ. БОННУ-ний тайланг боловсруулах явцад болон боловсруулж дууссаны дараа доорх саналыг үе шаттайгаар авна. Үүнд:


- Тухайн төсөл хэрэгжүүлэх нутгийн нөлөөллийн бүс (баг)-ийн иргэдээс санал авч, баг, хорооны Иргэдийн Нийтийн Хурлаар хэлэлцүүлсний дараа. (дэлгэрэнгүйг Бүлэг 2-оос харна уу)
- БОАЖЯ-ны Мэргэжлийн зөвлөлд танилцуулж, зөвлөлийн гишүүдийн олонхын саналаар дэмжвэл Ерөнхий шинжээчийн

тамга, гарын үсгээр баталгаажуулснаар БОННУ-ний тайлан батлагддаг.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн **8.4** дүгээр зүйлийн дагуу тус тайланг нийт 4 хувь боловсруулж, доорх байгууллагуудад тус бүр нэг хувь хүргүүлнэ.

1. БОАЖЯ-ны архивт
2. Төсөл хэрэгжүүлэгч,
3. Тайлан боловсруулсан мэргэжлийн байгууллага,
4. Төсөл хэрэгжүүлэх орон нутгийн удирдлагад тус бүр 1 хувь хүргүүлдэг. Эдгээр нь адил хүчинтэй байна.





н нөлөөллийн ерөнхий
элт гаргахад хуулиар
суурь баримт бичигт
гөлөв байдлын үнэлгээ
рчны төлөв байдлын
агтана. (БОНБУ-ний тухай
лт)

йлолтыг
с өмнө
газар
суурь
рилгоор
ай хууль,

A circular illustration depicting a forest landscape. In the foreground, a yellow mining truck with a large orange dump body is shown from the side, facing left. The ground is green with several brown tree stumps, indicating deforestation. A small pond with blue water and green reeds is in the middle ground. A brown bear stands on a small patch of land near the pond. The background is filled with various types of green trees, including tall evergreens and smaller deciduous trees. Three birds are flying in the sky above the trees. The entire scene is enclosed within a circular frame.

1.2.3 УУЛ УУРХАЙН МӨЧЛӨГ БА БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛӨЛ

Хөгжиж буй улсуудын хувьд уул уурхай нь эдийн засгаа чадавхжуулах боломжийг бий болгож байдаг. Иймээс ч Монгол Улс уул уурхайг тэргүүлэх салбараа болгон зарласан. Гэхдээ уул уурхай нь эдийн засгийн хувьд ач холбогдол өндөртэй ч зөв удирдахгүй бол байгаль орчны доройтлын томоохон эх үүсвэр болох талтай. Уул уурхайн төсөл нь эрэл, хайгуулаас уурхайн хаалт хүртэл эрдэс, түүхий эдээсээ шалтгаалаад хэд хэдэн үе шат, мөчлөгийг дамждаг. Эдгээр нь өөр өөрийн онцлогтой бөгөөд хэдэн жилээс хэдэн арван жил, бүр 100-гаас олон жил үргэлжлэх нь ч бий.




Байгаль орчинд үзүүлж буй сөрөг нөлөөллийг бууруулахад чиглэсэн цогц үйл ажиллагаа хэрэгжүүлэх замаар байгаль орчны хувьд тогтвортой байдал бүрдүүлэх боломжтой байдаг. Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ нь тухайн төслөөс үүсэж болзошгүй аливаа сөрөг нөлөөллүүдийг урьдчилан тооцож, нөлөөллийг бууруулах цогц арга хэмжээг тодорхойлон, төсөл хэрэгжүүлэгчид аргазүйн зөвлөмж өгдөг чухал баримт бичиг юм. Тухайлбал ус болон эрчим хүчний хэрэглээг бууруулах, эвдэрч буй газрын

болон ялгаруулж буй хог хаягдлын хэмжээг бууруулах, уурхайн талбай дахь хөрс, ус, агаарын бохирдлоос сэргийлэх, уурхайн хаалт болон нөхөн сэргээлтийг хэрхэн амжилттай хэрэгжүүлэх зэргийг байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тодорхойлдог.

Уурхайн хөгжлийн бүхий л шатанд байгаль орчны нөлөөлөл үүсдэг бөгөөд үе шат бүхэнд харилцан адилгүй ялгаатай тул эдгээр нөлөөллийг багасгахын тулд мөчлөг бүрд өөр өөр стратеги, арга хэрэгсэл болон технологийг ашигладаг.

Доорх хүснэгтээс уул уурхайн байгаль орчны нөлөөлөл, холбогдох зохицуулалтын шаардлага, арга хэрэгслийг үзнэ үү.

Мөчлөг	Нөлөөллийн эх сурвалж	Нөлөөнд өртсөн орчин	Байгаль орчны гол асуудлууд	Менежментийн арга барилууд
Хайгуул 	• Эрчимжсэн хайгуул (шороон замаар хүнд машин механизм явах, агаарын хэмжилт, суваг шуудуу ухах, өрөмдөх г.м.)	• Ургамлын бүрхэвч • Газар ашиглалт • Дуу чимээ • Усны чанар • Хөрс	• Эвдрэл, тунадасжилт • Мал амьтдыг түйвээх • Ой мод сүйтгэх • Газрыг талхлах • Химийн бодис, тос асгарснаас хөрс, ургамлын бүрхэвч хордох	• Төлөвлөгөө ба талуудын оролцоо • Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө • Гэрээлэгчийг сонгох • Хяналт шалгалт хийх • Хайгуулын дараах нөхөн сэргээлт
Уурхайн бүтээн байгуулалт 	• Барилга угсралт • Тээвэрлэлт • Уурхайн бэлтгэл • Кэмп	• Хөрс • Ургамлын бүрхэвч • Зэрлэг ан амьтан • Агаарын чанар • Усны чанар, хүрэлцээ • Дуу чимээ, чичиргээ	• Ой мод устгах, байгалийн унаган хэв шинжээ алдах • Хөрсний эвдрэл, гол горхины тунадасжилт • Мал амьтдыг түйвээх • Тоосжилт ихсэх • Гол горхи устгах • Худгийн усны түвшин буурах • Хаягдлын улмаас усны чанар муудах • Химийн бодис, тос асгарснаас хөрс ургамлын бүрхэвч хордох	• Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ • Уурхайн зураг төсөл хийх • Уурхайн ерөнхий загвар гаргах • Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө боловсруулах • Гэрээлэгчийг сонгох • Хяналт тавих


Мөчлөг	Нөлөөллийн эх сурвалж	Нөлөөнд өртсөн орчин	Байгаль орчны гол асуудлууд	Менежментийн арга барилууд
Олборлолт 	- Олборлолтын үйл ажиллагаа - Боловсруулалт - Тээвэр - Хаягдлыг устгах	- Хөрс - Ургамлын бүрхэвч - Зэрлэг ан амьтан - Агаарын чанар - Усны чанар, хүрэлцээ - Дуу чимээ, чичиргээ	- Хөрсний эвдрэл, гол горхины тунадасжилт - Газрын гүний болон гадаргын усны чанар, хүртээмж багасах - Ой мод устгах, байгаль унаган хэв шинжээ алдах - Тоосжилт нэмэгдэх - Хаягдлын далан эвдрэх - Уурхайн хүчиллэг усыг шүүрүүлэн зайлуулах (төмөрлөгийн болон нүүрсний уурхайд) - Газрын гүний болон гадаргын ус бохирдох (төмөрлөгийн уурхайд) - Химийн бодис, тос асгарснаас хөрс ургамлын бүрхэвч хордох	- Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө - Гэрээлэгчийг сонгох - Усыг цэвэршүүлэх - Хөрсийг цэвэршүүлэх - Хяналт тавих
Уурхайн хаалт 	- Уурхайн гадаргыг тэгшлэх, дүүргэх - Нөхөн сэргээлтийн үйл ажиллагаа - Хаалтын дараах ажил	- Хөрс ба геологи - Ургамлын бүрхэвч - Усны чанар - Зэрлэг ан амьтан - Агаарын чанар	- Хүдрийн хаягдлын овоолго, уурхайн налуугийн хана, уурхайн далангийн бат бэх байдал - Газрын гүний болон гадаргын усны бохирдол - Ургамлан бүрхэвч дахин сэргэхгүй байх - Уурхайн хүчиллэг усыг шүүрүүлэн зайлуулах (төмөрлөгийн болон нүүрсний уурхайд)	- Иргэдийн оролцоо - Хаалтын төлөвлөгөө ба хаалтыг санхүүжүүлэх - Хяналт тавих

Эх сурвалж: Английн ЭСЯ, НҮБХХ, Иргэний шийдэл: “Хариуцлагатай уул уурхай” гарын авлага



БҮЛЭГ 2. БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭНД ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦООГ ХАНГАХ ХУУЛЬ ЭРХЗҮЙН ОРЧИН

Монгол Улсын Их Хурал 1995 онд анх Байгаль орчныг хамгаалах тухай хуулийг баталжээ. 1998 онд Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний хууль батлагдахтай уялдан, тус хуульд байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний суурь зохицуулалтыг нэмж оруулсан байдаг (**БОХ тухай хууль, 7 ба 8 дугаар зүйл**).



ТА МЭДЭХ ҮҮ?


Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль нь бүс нутаг, салбарын хэмжээнд баримтлах бодлого, хэрэгжүүлэх хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөө болон аливаа төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлыг үнэлэх, хэрэгжүүлэх эсэх талаар дүгнэлт, шийдвэр гаргах, оролцогч талуудын харилцааг зохицуулдаг.

(БОНБУ-ний тухай хууль, 1.1 дэх заалт).

2012 онд УИХ-аас уг хуулийг шинэчилсэн найруулга хийж батлахдаа Олон нийтийн оролцооны зохицуулалт гэсэн 5 заалт бүхий **“Нөлөөллийн үнэлгээний үйл ажиллагааны олон нийтийн оролцоо”** гэдэг тусгай зүйлийг оруулсан байдаг (БОНБУ-ний тухай хууль, 18 дугаар зүйл).



1998 онд шинээр батлагдсан Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулиар тухайн нутаг дэвсгэрт хэрэгжих төслийн нөлөөллийн талаар мэдэх болон байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд санал өгөх эрхийг хангаж, тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.4.8 дахь заалтаар **“төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн иргэд, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчдийн санал”**-ыг Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайланд тусгахаар зохицуулж байжээ.



БОНБУ-ний тухай хуульд:

- Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд тусгах асуудлын жагсаалтад "төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн захиргаа, төслийн нөлөөлөлд өртөх нутгийн иргэдийн нийтийн хурлын санал, тэмдэглэл"-ийг оруулсан. /8.4.8 дахь заалт/
- Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан төсөл хэрэгжүүлэгч, үнэлгээ хийсэн мэргэжлийн байгууллага хамтран төслийн нөлөөлөлд өртөх орон нутгийн оршин суугчдад танилцуулах ажлыг зохион байгуулна /10.5 дахь заалт/
- Төслийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийж байгаа хуулийн этгээд тайлан боловсруулах явцдаа төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн захиргаа, төслийн нөлөөлөлд өртөх нутгийн иргэд, оршин суугчдаас албан ёсоор санал авч, хэлэлцүүлэг зохион байгуулна /18.4 дэх заалт/
- Олон нийтийн оролцооны асуудлыг журмаар зохицуулах бөгөөд үг журмын байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална /18.5 дахь заалт/

Тус хуулийн 18.5 дахь заалтын дагуу Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны 1 дүгээр сарын 06-ны өдрийн А-03 тоот тушаалаар Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах тухай журмыг баталжээ.

**ТА МЭДЭХ ҮҮ?**

Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх, түүнтэй холбогдсон шийдвэр гаргах, оролцогч талуудын хооронд үүсэх харилцааг зохицуулахад Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний журмын зорилго оршино. Уг журмаар дараах асуудлыг зохицуулна. Үүнд:

- Байгаль орчны төлөв байдлын үнэлгээ
- Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ, түүнд тавигдах шаардлага
- Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ, түүнд тавигдах шаардлага
- Байгаль орчны менежментийн төлөвлөгөө
- Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний шинжилгээ
- Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах, түүнийг хянаж хүлээн авах
- Байгаль орчны үнэлгээний мэдээллийн сан, хянан магадлагаа
- Мэргэжлийн зөвлөлийн үйл ажиллагаа

**2.1. БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНД ОЛОН
НИЙТИЙН ОРОЛЦООГ ХАНГАХ ЖУРАМ**

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах журмыг Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны 1 дүгээр сарын 06-ны өдрийн А-03 тоот тушаалаар баталсан байдаг. Тус журмын дагуу үнэлгээний

төрлөөс хамаарч олон нийтийн оролцоог харилцан адилгүйгээр хангах, тухайн оролцоог хангах ажлыг хариуцах байгууллага, арга хэлбэр зэргийг зохицуулсан байдаг.

Тухайлбал:

Үе шат	Журмын заалтууд
Нөлөөллийн үнэлгээ хийхээс өмнө	2.4.1. Орон нутгийн захиргааны байгууллага нь тухайн орон нутагт хэрэгжих төслийн талаарх мэдээллийг олон нийтэд нээлттэй байлгах; 2.4.2. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон орон нутгийн байгууллага нь байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээний шийдвэр, тухайн төсөлд иргэд, олон нийтээс өгсөн саналыг байгаль орчны мэдээллийн санд оруулах;
БОННУ хийх явцад	2.5.3. Нөлөөллийг таамаглах үе шатанд иргэдтэй уулзалт хийх, оролцооны аргаар үнэлэх аргачлалыг ашиглан иргэдийн саналыг бүрэн авах; 2.5.4. Нөлөөллийн үнэлгээний үе шатанд олон нийтийн оролцоог зөвлөгөөн, хэлэлцүүлэг, санал асуулга явуулах замаар төслийн шууд болон шууд бус нөлөөллийг үнэлж, иргэдийн амьжиргаа, нийгмийн асуудлыг тусгахад анхаарах; 2.6. Төсөл хэрэгжүүлэгч төслийн талаарх ойлголт, эерэг, сөрөг нөлөөлөл, түүнийг бууруулах арга хэмжээний талаар нөлөөлөлд өртөж болзошгүй иргэдэд дэлгэрэнгүй танилцуулж, иргэд, олон нийтийн оролцоог хангахад шаардагдах баримт бичгийг бүрдүүлж өгч болно;

Үе шат	Журмын заалтууд
БОННУ-ний тайланг боловсруулж дууссаны дараа	2.7. Үнэлгээний эрх бүхий аж ахуйн нэгж нь төсөл хэрэгжүүлэгчтэй хамтран Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан болон Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулж дууссаны дараа үнэлгээний тайлан, олон нийтийн саналын нэгдсэн дүнг ажлын 15 өдрийн хугацаанд тухайн нутаг дэвсгэрийн баг, хорооны нийтийн хурлаар хэлэлцүүлж санал авна; 2.8. Хэрэв тухайн төсөл нь хэд хэдэн баг, сумын нутаг дэвсгэрийг хамарч хэрэгжих бол тухайн сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал, багийн Иргэдийн нийтийн хуралд тус тусад нь танилцуулж санал авна; 2.10. Нөлөөлөлд өртөж болзошгүй иргэд нь байгаль орчны нөлөөллийн үнэлгээтэй холбогдсон саналаа тухайн баг, хорооны Иргэдийн нийтийн хуралд төслийн талаар эцсийн шийдвэр гаргахаас өмнө хүргүүлсэн байна;
БОННУ батлагдсаны дараа	1.5. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь стратегийн үнэлгээ хийгдсэн хөгжлийн бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө болон байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд хамрагдсан төслүүдийн талаарх, аймаг, нийслэлийн байгаль орчны алба нь байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд хамрагдсан төслүүдийн талаарх мэдээллийг цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэх ажлыг зохион байгуулна. Менежментийн төлөвлөгөөг олон нийтэд нээлттэй байлгана; 2.11. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний батлагдсан тайланг олон нийтэд нээлттэй байлгах үүргийг төсөл хэрэгжүүлэгч, сум дүүргийн Засаг дарга, баг, хорооны Иргэдийн нийтийн хурал болон аймаг нийслэлийн байгаль орчны газар хариуцна; 2.12. Төсөл хэрэгжүүлэгч нь батлагдсан Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх явцад олон нийтийн оролцоог хангаж, хэрэгжилтийг жилд нэгээс доошгүй удаа тухайн төсөл хэрэгжиж буй нутгийн иргэд, олон нийтэд танилцуулж байна;
Гомдол маргаан шийдвэрлэх	3.5. Үнэлгээний тайлангийн талаарх гомдол, маргааныг иргэд, олон нийтийн зүгээс төсөл хэрэгжүүлэгч, тухайн төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг хийсэн эрх бүхий аж ахуйн нэгж, орон нутгийн удирдах байгууллагад эхлэн гаргана; 3.7. Шат дараалан тавьсан гомдол, маргааны шийдвэрийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага холбогдох хууль тогтоомжийн хүрээнд гаргах бөгөөд хянан шийдвэрлэсэн дүгнэлтийг иргэд, олон нийт хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд шүүхээр шийдвэрлүүлэх эрхтэй;



БҮЛЭГ 3. БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭНД ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦООГ ХАНГАХ НЬ

Гарын авлагын өмнөх бүлгүүдэд байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тухай, байгаль орчны нөлөөллийн үнэлгээний үе, шатууд болон хууль, эрх зүйн баримт бичгүүдийн талаар та бүхэнд мэдээлэл өгсөн билээ.

Энэ хэсэгт олон нийтийн оролцоог хангахад оролцогч талуудын эрх үүрэг, байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд олон нийтийн оролцоог хангахад тулгамдаж буй асуудал, түүнийг хэрхэн сайжруулах талаар хууль, журам, олон улсын байгууллага, иргэний нийгмийн байгууллагуудын хийсэн судалгаа, гарын авлага материал дээр үндэслэн мэдээлэл хуваалцах болно.



ТА МЭДЭХ ҮҮ?

Та оролцсоноор: Эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхээ хангаж, нийгмийн баялгаас тэгш хүртэх, сайн сайхан амьдралынхаа эх үүсвэрийг бүрдүүлэх боломжтой болно.

Хэрвээ та ямар нэгэн зүйл болохгүй байгааг мэдэж байгаа бол тухайн асуудлын том, жижгээс үл хамааран уг асуудлыг бусадтай хамтран өөрчлөх хэрэгтэй юм байна гэж бодох үеэс оролцоо эхэлнэ. Жишээ нь, иргэд амьдарч буй газарт нь хэрэгжүүлэх гэж байгаа төслийн байгаль орчинд үзүүлэх эерэг, сөрөг нөлөөг хэлэлцэх хуралд оролцсоноор, хуралд саналаа хэлснээр, саналынхаа дагуу эргэх холбоо тогтоож, хяналт тавьж хариуцлага тооцдог болсноор буюу оролцооны ач тусыг мэдсэнээр дараа дараагийн шийдвэр гаргах үйл явцад идэвхтэй оролцож эхэлдэг.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог хангах гэдэг нь төсөл хэрэгжүүлэгч болон төслийн нөлөөлөлд өртөж болзошгүй **нутгийн иргэд, орон нутгийн холбогдох байгууллагын төлөөлөл** (оролцогч талууд) төслийн байгаль орчны нөлөөлөлтэй холбоотой хоорондын мэдээллээ **ил тод, хүртээмжтэй солилцох, зөвлөлдөх, зөвшилцөх, иргэдийн амьжиргаа, эрүүл мэндэд шууд** болон дамаар нөлөөлж болзошгүй төслийн төлөвлөлтөд оролцогч талуудын саналыг тусгах, төрийн шийдвэр гаргалтад иргэдийн дуу хоолойг хүргэх үйл явц юм.

3.1. ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦООГ ХАНГАХАД ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ

Байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах, саналыг авахад төсөл хэрэгжүүлэгч, үнэлгээний мэргэжлийн байгууллага, орон нутаг, төрийн захиргааны байгууллага зэрэг олон талт хамтын ажиллагаа шаардлагатай байдаг. Байгаль орчны нөлөөллийн үнэлгээтэй холбоотой мэдээллийг олон нийтэд нээлттэй байлгах асуудлыг төрийн болон орон нутгийн захиргааны байгууллагууд хариуцдаг. Доорх хүснэгтээс холбогдох талуудын хууль, журмаар хүлээсэн эрх, үүргийн талаар мэдэх боломжтой.



Д/д	Оролцогч талууд	Эрх	Үүрэг	Хууль, эрхзүйн заалт
1	Байгаль орчин, аялал жуулчлалын яам		• БОНУ-д хамрагдсан төслүүдийн талаарх мэдээллийг цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэх; • Олон нийтийн оролцооны асуудлын журмыг батлах; • Олон нийтийн оролцоог хангахад шаардагдах бодлогын баримт бичиг, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай холбогдох журам, заавар, аргачлалыг иргэд, олон нийтэд нээлттэй байлгах;	• БОНБТХууль 18.1 дэх заалт; • БОНБТХууль 18.2 дахь заалт; • БОНБТХууль 18.5 дахь заалт; • БОНБУОНОХТЖ 1.4 дэх заалт;
2	Аймаг, нийслэлийн байгаль орчны газар		• Олон нийтийн оролцоог хангахад шаардагдах бодлогын баримт бичиг, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай холбогдох журам, заавар, аргачлалыг иргэд, олон нийтэд нээлттэй байлгах; • Байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд хамрагдсан төслүүдийн талаарх мэдээллийг цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэх ажлыг зохион байгуулна; • Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний батлагдсан тайланг олон нийтэд нээлттэй байлгах;	• БОНБУОНОХТЖ 1.4 дэх заалт; • БОНБУОНОХТЖ 1.5 дахь заалт; • БОНБУОНОХТЖ 2.11 дэх заалт;
3	Сумын засаг дарга		• Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний батлагдсан тайланг олон нийтэд нээлттэй байлгах;	• БОНБУОНОХТЖ 2.11 дэх заалт;
4	Багийн засаг дарга		• Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний батлагдсан тайланг олон нийтэд нээлттэй байлгах;	• БОНБУОНОХТЖ 2.11 дэх заалт;

Д/д	Оролцогч талууд	Эрх	Үүрэг	Хууль, эрхзүйн заалт
5	Мэргэжлийн байгууллага		Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн захиргаа, төслийн нөлөөлөлд өртөх • нутгийн иргэд, оршин суугчдаас албан ёсоор санал авч, хэлэлцүүлэг зохион байгуулна; Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний үе шатанд олон • нийтийн оролцоог хангана; Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан болон • байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулж дууссаны дараа үнэлгээний тайлан, олон нийтийн саналын нэгдсэн дүнг ажлын 15 өдрийн хугацаанд тухайн нутаг дэвсгэрийн баг, хорооны иргэдийн нийтийн хурлаар хэлэлцүүлж санал авна;	БОНБТХууль 18.4 дэх заалт; БОНБТХууль 8.4.8 дахь заалт; БОНБУОНОХТЖ 2.5.1 дэх заалт; БОНБУОНОХТЖ 2.7 дахь заалт;
6	Төсөл хэрэгжүүлэгч		Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг нутгийн оршин • суугчид, орон нутгийн захиргаа, төслийн нөлөөлөлд өртөгч талууд холбогдох төрийн захиргааны төв байгууллагад тогтоосон хугацаанд мэдээлж, тайлагнах; Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд олон нийтийн оролцоог • хангахтай холбоотой арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай зардлыг бодлого, хөтөлбөр санаачлагч, төсөл хэрэгжүүлэгч хариуцна; Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний батлагдсан тайланг • олон нийтэд нээлттэй байлгах;	БОНБТХууль 14.1.2 дахь заалт; БОНБТХууль 3.1 дэх заалт; БОНБУОНОХТЖ 2.11 дэх заалт;
7	Иргэд олон нийт	Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлангийн талаарх гомдол, маргааныг иргэд, олон нийтийн зүгээс төсөл хэрэгжүүлэгч, тухайн төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг хийсэн эрх бүхий аж ахуйн нэгж, орон нутгийн удирдах байгууллагад эхлэн гаргана	Нөлөөлөлд өртөж болзошгүй иргэд нь байгаль орчны нөлөөллийн • үнэлгээтэй холбогдсон саналаа тухайн баг, хорооны Иргэдийн нийтийн хуралд төслийн талаар эцсийн шийдвэр гаргахаас өмнө хүргүүлсэн байна; Төслийг хэлэлцэх, үнэлэх, батлах явцад олон нийтийн зүгээс тавигдах • аливаа шаардлага нь холбогдох хууль тогтоомжийн хүрээнд байна;	БОНБТХууль 2.10 дахь заалт; БОНБТХууль 3.4 дэх заалт; БОНБТХууль 3.5 дахь заалт; БОНБТХууль 3.6 дахь заалт; БОНБТХууль 3.7 дахь заалт;

Д/д	Оролцогч талууд	Эрх	Үүрэг	Хууль, эрхзүйн заалт
7		- Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тайланд тусгагдаагүй, эсвэл дутуу орсон, буруу хийсэн зэргээс үүдэлтэй гомдол маргааныг иргэд, олон нийтийн зүгээс төсөл, орон нутгийн удирдах байгууллага болон байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад шат дараалан тавина; - Шат дараалан тавьсан гомдол, маргааны шийдвэрийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага холбогдох хууль тогтоомжийн хүрээнд гаргах бөгөөд хянан шийдвэрлэсэн дүгнэлтийг иргэд, олон нийт хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд шүүхээр шийдвэрлүүлэх эрхтэй;		

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.5-д заасан тодорхойлолтын дагуу **“нутгийн өөрөө удирдах байгууллага”** гэж аймаг, сум, нийслэл, дүүргийн **Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал**, баг, хороонд иргэдийн шууд оролцоо бүхий **“Иргэдийн Нийтийн Хурал”**-ыг ойлгоно. Тус хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2-т заасны дагуу “иргэн аймаг, сум, нийслэл, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд сонгогдох, төлөөлөгчийг сонгох, баг, хорооны Иргэдийн Нийтийн Хуралд өөрөө оролцох, нутгийн өөрийн удирдлагын байгууллагад өргөдөл, гомдол гаргаж шийдвэрлүүлэх, хууль тогтоомжид заасан журмын дагуу мэдээлэл авах эрхтэй” байна.

Дээрх хуульд тусгасан иргэдийн **“хууль тогтоомжид заасан журмын дагуу мэдээлэл авах эрх”**-ийг хангах нэг хэлбэр нь Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний

тухай хууль болон **“Байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах”** журмын хэрэгжилтийг хангах явдал юм.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2-д тусгасны дагуу багийн Иргэдийн Нийтийн Хурал нь нутаг дэвсгэрийн хүрэн дэх аливаа тулгамдсан асуудлыг хэлэлцэх үүрэг хүлээдэг.

Иргэдийн Нийтийн Хурлын ээлжит хуралдааныг улиралд нэг хуралдуулах (МУЗЗНДНТУТухай хууль, 46.2) бол харин Иргэдийн Нийтийн Хурлын ээлжит бус хуралдааныг Хурлын Зөвлөл, Засаг даргын санаачилгаар, эсхүл баг, хорооны сонгуулийн эрх бүхий иргэдийн арваас доошгүй хувь нь санал болгосноор хуралдуулна. Иргэд саналаа гарын үсэг зурах хэлбэрээр илэрхийлнэ. (МУЗЗНДНТУТухай хууль, 46.4).

“Байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах” журмын (2.7) дагуу төсөл хэрэгжүүлэгч эсвэл үнэлгээ хийж буй мэргэжлийн байгууллага тухайн баг, хорооны ИНХ-ыг хуралдуулах хүсэлт гаргаснаас ажлын 15 өдрийн дотор ИНХ-ын хуралдааныг зохион байгуулж, тухайн БОННУ-ний тайланд иргэдийн саналыг тусгах шаардлагатай ба ИНХ зохион байгуулах үүргийг баг, хорооны Иргэдийн Нийтийн Хурлын Зөвлөл буюу түүний бүрэлдэхүүнд багтах иргэдийн төлөөлөл, баг, хорооны Засаг дарга болон Хуралдааны дарга, хорооны хэсгийн ахлагч нар хариуцна. (МУЗЗНДНТУТухай хууль, 39.9).

ИНХ-аар төслийн БОННУ-ний тайланг хэлэлцүүлсэн тохиолдолд аливаа шийдвэр гаргахгүй буюу Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд (8.4.8 ба 18.4) заасны дагуу ИНХ зөвхөн тухайн БОННУ-ний тайланг хэлэлцсэн тухай, иргэдээс өгсөн саналуудыг багтаасан Иргэдийн нийтийн хурлын санал, тэмдэглэл гаргаж, төсөл хэрэгжүүлэгч эсвэл үнэлгээний тайлан боловсруулж буй мэргэжлийн байгууллагад өгнө.

Баг, хорооны Иргэдийн Нийтийн Хурлын Зөвлөл буюу түүний бүрэлдэхүүнд багтах иргэдийн төлөөлөл, баг, хорооны Засаг дарга болон Хуралдааны дарга, хорооны хэсгийн ахлагч нар хэрэв хуулиар хүлээсэн үүрэг, хариуцлагаа хангалттай хэрэгжүүлээгүй, ИНХ-ыг хуулийн хүрээнд хуралдуулаагүй, эсвэл хэлэлцсэн БОННУ-ний тайлантай холбоотой хууль бус шаардлага тавьсан, ИНХ-ын санал, тэмдэглэлийг тухайн төсөл хэрэгжүүлэгч эсвэл үнэлгээ хийж буй мэргэжлийн байгууллагад гаргаж өгөхгүй байх зэргээр албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах, хэтрүүлэх, албан үүргээ гүйцэтгэх, эсхүл гүйцэтгэхгүй байхтай холбогдуулан бусдаас шан харамж шаардах, албан үүргээ гүйцэтгэхдээ хууль бусаар бусдын эрхийг хязгаарлах үйлдэл гаргавал **Авлигын эсрэг хуулийн 7.1.3, 7.1.5, 7.1.6** дугаар заалтаар хориглосон үйл ажиллагаа гэж үзэн тус хуулийн 8 дугаар зүйл, 9 дүгээр зүйлийг үндэслэн Иргэн, хуулийн итгээд Авлигатай тэмцэх газарт өргөдөл, гомдол гаргаж, мэдээлэл өгч болно.

БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭНД ОЛОН НИЙТИЙГ ОРОЛЦУУЛСАН САЙН ТУРШЛАГА

Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжсэн “Дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих” төслийн хүрээнд Улаанбаатар хотын захын оршин суугчид, сургууль, цэцэрлэг, эмнэлэг зэрэг газруудын түүхий нүүрсний шаталтаас үүсэж буй агаарын бохирдлыг бууруулах зорилготой “Нүүрснээс нийлэг байгалийн хий (НБХ) гарган авах үйлдвэр” байгуулах төслийн Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг

2016-2019 онд үнэлгээний мэргэжлийн байгууллага болох “Грийнтрендс” ХХК-ийн зөвлөх баг боловсруулсан байна.

Ингэхдээ Дэлхийн Банкны “Олон нийтийн хэлэлцүүлэг, Мэдээллийн нээлттэй байдлын тухай” журам болон Монгол Улсын “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах тухай журам”-ын дагуу Нүүрснээс НБХ гарган авах үйлдвэр байгуулах төслийн БОННУ-ний төслийг

тухайн үйлдвэр болон хий дамжуулах шугам хоолой баригдах нөлөөллийн бүсэд хамаарагдах орон нутгийн холбогдох оролцогч талуудад ил тод, нээлттэй хэлэлцүүлэн, БОННУ-ний тайлангийн

төсөлд тэдгээрийн санал зөвлөмжийг авчээ. Та бүхэнд энэхүү БОННУ-ний тайланд хэрхэн олон нийтийн саналыг тусгаж ажилласан талаар бодит жишээг хүргэе.

ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН БЭЛТГЭЛ:

Дэлхийн Банкны Олон нийтийн хэлэлцүүлэг, Мэдээллийн нээлттэй байдлын журам болон Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд Олон нийтийн оролцоог хангах тухай журам болон төслийн Олон нийтийн хэлэлцүүлгийн төлөвлөгөөний дагуу доорх ажлуудыг үе шаттайгаар гүйцэтгэжээ.

ҮЕ ШАТ I: Хэлэлцүүлгийн бэлтгэл үе шат ба хэлэлцүүлгийн талаар урьдчилан мэдээлэл өгөх үе шатанд:

Төслийн санхүүжүүлэгч, төсөл хэрэгжүүлэгч, үнэлгээний мэргэжлийн байгууллага хамтран хэд хэдэн уулзалт зохион байгуулж, төслийн хэлэлцүүлгийн хамрах талбай, оролцогч талуудыг тодорхойлж жагсаалт гаргав. Үүнд БОННУ-ний тайлангийн төслийн үйлдвэр болон хийн шугам хоолой баригдах талбайд хамаарах 5 дүүргийн 8 хороо, 1 аймгийн 6 сумдын иргэд, малчид, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийг хамруулжээ.

Төслийн санхүүжүүлэгч, төсөл хэрэгжүүлэгч, үнэлгээний мэргэжлийн байгууллага хамтран хэлэлцүүлгийн гол материал болох БОННУ-ний тайлангийн төсөл, Техникийн болон Техникийн бус хураангуйг боловсруулав. Мөн хэлэлцүүлгийн туслах материалууд болох хэлэлцүүлгийн зарлал, урилга, хөтөлбөр,

илтгэл, хэлэлцүүлгийн сэдэв, хэлэлцүүлгийн зохион байгуулалтад санал авах хуудас, хэлэлцүүлгээс өмнө болон хойш 14 хоногийн турш ЗДТГ болон ИТХ/ИНХ-д байршуулах санал авах дэвтэр, хэлэлцүүлгийн материал хүлээлцсэн маягт, бүртгэлийн хуудас, анонс, зурагт хуудас, түгээмэл асуултуудыг боловсруулжээ.

Нийслэлийн 5 дүүрэг, 1 аймгийн 6 сум тус бүрийн холбогдох талуудад олон нийтийн хэлэлцүүлэг явуулах тухай мэдээллийг урьдчилан өгч, хэлэлцүүлгийн материал тараах, уулзалтыг товлох тухай Байгаль орчин, аялал жуулчлалын яамны албан бичгийн хамт илгээжээ.

Төслийн санхүүжүүлэгч, төсөл хэрэгжүүлэгч, үнэлгээний мэргэжлийн байгууллага хамтарсан баг 5 дүүрэг, 1 аймгийн 6 сумдад орон нутгийн удирдлагууд болон мэргэжилтнүүд, иргэд, малчид, ТББ-ын төлөөлөл гэх мэт орон талын оролцоог хангасан төлөөллүүдтэй урьдчилан товлосон өдрүүдэд уулзалт зохион байгуулан, хэлэлцүүлгийн ач холбогдол, зорилго, хэлэлцүүлэгт яагаад идэвхтэй оролцох ёстой, яагаад орон нутагтаа хэлэлцүүлгийн талаар сурталчлах үүрэг хүлээж байгааг тайлбарлан, хэлэлцүүлгийн материалыг тарааж, огноог тохиролцон, хэлэлцүүлэг даргалагчийг тодорхойлов.

МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ:

ҮЕ ШАТ II: Хэлэлцүүлгийг зарлах, мэдээллийг нээлттэй, ил тод болгох ажлын хүрээнд нутгийн удирдлагын байранд, орон нутгийн ТВ болон цахим хуудаснуудад мэдээллийг байршуулсан. Мөн хэлэлцүүлгийн зарыг хэд хэдэн телевиз, сонин, орон нутгийн цахим хуудсуудаар дамжуулан түгээсэн. Төслийн санхүүжүүлэгч, төсөл хэрэгжүүлэгч, үнэлгээний мэргэжлийн байгууллага хамтран хэлэлцүүлгийн холбогдох багц материалыг Монгол болон Англи хэл дээр боловсруулан бэлтгэж, хэлэлцүүлэг болохоос 14 хоногийн өмнө олон нийтэд нээлттэй болгон, орон нутгийн болон санхүүжүүлэгч төслийн цахим хуудсанд байршуулсан.

Энэхүү ажлын хүрээнд 4 дүүрэг, 1 аймгийн 9 сумын 67 иргэдтэй уулзаж мэдээлэл өгч, хэлэлцүүлгийн материалыг хэлэлцүүлэг

явуулахаас өмнө холбогдох талуудад биечлэн тараасан.

Холбогдох засаг захиргааны байгууллагууд тэр дундаа хороо болон багийн Засаг дарга нар, хэсгийн ахлагч нартай хэлэлцүүлгийн мэдээллийг урьдчилсан байдлаар иргэдэд хүргэх ажлыг хамтран гүйцэтгэсэн. Ингэхдээ бүх хороод, багийн Засаг дарга нарт иргэдэд тараах хэлэлцүүлгийн материалыг хангалттай тоогоор хүлээлгэн өгч, материал хүлээлцсэн маягтыг иргэдээр бөглүүлж гарын үсэг зуруулжээ. Хэлэлцүүлгийн материал тараахдаа хэлэлцүүлэг ямар ач холбогдолтой, яагаад иргэд хэлэлцүүлэгт оролцож, санал бодлоо илэрхийлэх нь чухал болон хэлэлцүүлгийн материалын агуулгыг тайлбарласан сургалт хийв.

ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН БАГЦ МАТЕРИАЛД:

- Нүүрснээс НБХ гарган авах үйлдвэр байгуулах төслийн БОННУ-ний тайлангийн төсөл
- Нүүрснээс НБХ гарган авах үйлдвэр байгуулах төслийн БОННУ-ний тайлангийн төслийн Техникийн хураангуй,
- Нүүрснээс НБХ гарган авах үйлдвэр байгуулах төслийн БОННУ-ний тайлангийн төслийн Техникийн бус хураангуй
- Санал авах дэвтэр

Дээрх хэлэлцүүлгийн материалуудыг хэвлэмэл хэлбэрээр санал авах дэвтрийн хамт орон нутгийн ЗДТГ болон Иргэний танхимд байршуулжээ.

Хэлэлцүүлэг болохоос 14 хоногийн өмнө төсөл

санхүүжүүлэгчийн цахим хуудсанд хэлэлцүүлгийн урилга, хөтөлбөр болон хэлэлцүүлгийн материалуудыг Англи, Монгол хэлээр байршуулж зарлав.

Мөн хэлэлцүүлгийн дэлгэрэнгүй зарыг холбогдох сум, дүүргийн Фейсбүүк хуудас болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд түгээв.

Оролцогчдыг хэлэлцүүлэгт оролцох эсэхийг утсаар лавлан баталгаажуулав.

Хэлэлцүүлгийн сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулагдахаас өмнө 14 хоног, хэлэлцүүлэг явуулснаас хойш 14 хоногийн турш санал хүсэлт, зөвлөмжийг дараах сувгаар хүлээн авав.



ИЛТГЭЛ БЭЛТГЭСЭН БАЙДАЛ:

Илтгэлийг Монгол Улсын бодлого, төсөл хэрэгжүүлэх үндэслэл, төслийн хөрөнгө оруулалт, эдийн засгийн өгөөж, үйлдвэр, хий дамжуулах шугам хоолойн байршил, байгаль орчин, нийгмийн болзошгүй нөлөөлөл, Байгаль орчин, нийгмийн төлөв байдлын судалгаа, Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ, Хуримтлагдах нөлөөлөл, Хувилбаруудын дүн шинжилгээ, Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, дүгнэлт гэсэн агуулгатайгаар

Дэлхийн банк болон УУДБХОДТөслийн мэргэжилтнүүдийн зөвлөмжийн дагуу БОННУ-ний тайлангийн агуулга, үр дүнд үндэслэн боловсруулав.

Илтгэлийг товч бөгөөд зураг, хүснэгт байдлаар иргэдэд ойлгомжтой, мэргэжлийн үг хэллэг аль болох ашиглахгүйгээр бэлтгэсэн.

САНАЛ АВАХ ЖУРНАЛ/ДЭВТЭР:

Төслийн санхүүжүүлэгч, төсөл хэрэгжүүлэгч, үнэлгээний мэргэжлийн байгууллага хамтран хэлэлцүүлэг зохиогдох өдрөөс 14 хоногийн өмнө хэлэлцүүлгийн багц материалыг санал авах журналын хамт нөлөөллийн бүсийн аймаг, дүүрэг, хороо, сумдын ЗДТГ болон Иргэний танхимд байршуулж, оролцогч

талууд хэлэлцүүлгийн дараа 14 хоногийн дотор саналаа өгөх боломжийг хангасан. Хэлэлцүүлэг тус бүр дээр хурал даргалагч нь саналын журналд бичгээр санал өгөх боломжтойг оролцогчдод мэдээлж байсан.

ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ:

Олон нийтийн хэлэлцүүлгийг Улаанбаатар хотын Багануур, Баянзүрх, Налайх, Хан-Уул, Сонгинохайрхан дүүрэг, Төв аймгийн Зуунмод, Алтанбулаг, Архуст, Баяндэлгэр, Сэргэлэн, Эрдэнэ сумдыг хамруулан нийт 4 удаа зохион байгуулав.

Хэлэлцүүлэгт оролцогчдыг бүртгэн гарын үсэг зуруулж, хэлэлцүүлгийн материалуудыг тараасны дараа төслийн

танилцуулга хийж, үүний дараагаар зөвлөх багийн төлөөллөөс Нүүрнээс НБХ гарган авах үйлдвэр байгуулах төслийн БОННУ-ний тайлангийн төслийн талаар илтгэл тавьж, дараа нь 1 цаг асуулт хариулт явуулсан. Асуулт хариултын дараа амаар саналуудыг авч, амаар санал өгч чадаагүй иргэдээс саналын хуудас бөглүүлэн, хурааж авснаар хэлэлцүүлэг өндөрлөсөн.



ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ:

ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ДАРААХ ҮЕ:

5 дүүрэг, 1 аймгийн 6 сумдад байршуулсан 14 саналын дэвтрийг хэлэлцүүлэг дууссанаас хойш 14 өдрийн дараа цуглуулж дуусав.

Олон нийтийн хэлэлцүүлгийн үеэр аман болон бичгээр өгсөн саналууд, хэлэлцүүлгийн дараа 14 хоногийн турш бүх боломжит сувгуудаар ирүүлсэн нэмэлт саналуудыг нэгтгэн дүгнэж, үнэлээд БОННУ-ний тайлангийн төслийн холбогдох хэсэгт тусгасан.

Олон нийтийн хэлэлцүүлгийн тайланг дараах хавсралтуудын хамт эцэслэн боловсруулж, төслийн цахим хуудаснаа байршуулан олон нийтэд нээлттэй болгов.

Сайжруулан боловсруулсан БОННУ-ний тайлангийн төсөл болон оролцогч талуудын санал хэрхэн туссаныг харуулсан Асуулт, хариултын хүснэгтийг 5 дүүрэг, 6 сумд руу шуудангаар болон оролцогч талууд руу цахим шуудангаар дамжуулан мэдээлснээр хэлэлцүүлэг, санал авах ажил дуусгавар болжээ.

3.1.1. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ТЭГШ, ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДЛЫГ ХАНГАХ

Хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль, журмын дагуу оролцогч талуудад төсөл хэрэгжүүлэгч, үнэлгээний мэргэжлийн байгууллага, нөлөөлөлд өртөж болзошгүй нутгийн иргэд, орон нутгийн захиргааны байгууллагуудыг хамруулан ойлгоно гэж тодорхойлсон байдаг.

Оролцогч тал нь хувь иргэн, сонирхлын бүлгүүд, төрийн байгууллагууд болон хувийн аж ахуйн нэгжүүд байж болно. Мөн улстөрчид, холбоод, үйлдвэрчний эвлэл, эрдэм шинжилгээний байгууллагууд, байгаль орчны бүлэг холбоод эвслүүд, төсвийн байгууллагууд болон хэвлэл мэдээллийн байгууллагууд багтаж болно. Харин олон улсын сайн туршлагыг харвал эдгээрээс гадна тухайн бүс нутагт үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгжүүд, төрийн бус байгууллагууд, төслийг сонирхож буй орон нутгийн болон бүс нутгийн бусад төрийн болон төрийн бус эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагууд багтаж болно. Иймд, оролцогч талуудын тэгш оролцоог хангах зорилгоор оролцогч талуудаа бүрэн тодорхойлох шаардлагатай.

Алхам 1. Оролцогч талуудыг матрицын эсвэл зураглалын арга ашиглан тодорхойлох ба эдгээр аргууд нь төслийн шууд болон дам нөлөөлөлд өртөж болзошгүй, тухайн төслийн үйл ажиллагааг сонирхсон эсвэл нөлөөлөлд өртөж магад гэж өөрийгөө үзэж буй оролцогч талуудыг орхигдуулалгүй тодорхойлоход туслах энгийн хэрэглүүр юм.




ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЗУРАГЛАЛ

Оролцогч талуудын дунд хэн нь бодлого, шийдвэрт хамгийн сайн, эсвэл хамгийн их сөрөг нөлөөлөл үзүүлэхийг мэдэх, өөр өөр сонирхол, нөлөөлөх байдал нь ялгаатай оролцогчидтой хэрхэн ажиллах нь зүйтэйг тодорхойлохдоо “оролцогч талуудын зураглал” арга хэрэгслийг ашиглана.¹⁰

¹⁰ Төлөвлөлт, хяналт шинжилгээ, үнэлгээний гарын авлага, Sarthi Acharya, Г. Ганзориг, Н. Одмаа, 2016 он, 110-112 дахь тал

Оролцогч талуудын сонирхол, нөлөөллийг шинжлэх нь



ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН МАТРИЦ

Багийн хуралд оролцогч талууд, бүлгүүд

Орон нутаг

- Хамгийн ойрхон оршиж буй нутгийн иргэд /малчид/ байгууллагууд
- Төслийн үйл ажиллагаатай ойрхон суурьшмал бүс /сум/ багийн төв
- Компанийн сайт, оффистой ойрхон суурьшмал бүс
- Тогтмол хажуугаар нь өнгөрдөг орон нутгийн иргэд /малчид/ байгууллагууд

Эмзэг бүлгийн иргэд

- Эмэгтэйчүүд /өрх толгойлсон эмэгтэйчүүд
- Хөгшид /хөгжлийн бэрхшээлтэй иргэд/ өвчтэй хүмүүс
- Хүүхэд /сургууль/ өнчин хүүхэд асрах төвүүд/ хүүхэд, залуучуудын бүлэг, клуб
- Бусад

Төрийн захиргааны байгууллага

- Багийн иргэдийн хурал/ засаг дарга
- Сумын ИТХ /засаг дарга/ засаг захиргааны ажилтнууд
- Аймгийн ИТХ/ засаг дарга /засаг захиргааны ажилтнууд
- Яам /агентлаг/ төрийн захиргааны байгууллагууд/ тэдгээрийн орон нутаг дахь салбарууд

Мэргэжлийн холбоод ба бусад

- Улс төрийн намууд
- Мэргэжлийн холбоод
- Үйлдвэрчний эвлэл
- Хөгжлийн байгууллагууд
- Тусламжийн байгууллагууд
- Боловсролын байгууллагууд
- Сүм, хийд
- Бусад

Төсөл хэрэгжүүлэгч

- Дээд удирдлага
- Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчны хэлтэс
- Ажилтнууд
- Бусад

Үнэлгээний мэргэжлийн байгууллага

- Гүйцэтгэх удирдлага
- Үнэлгээ хийсэн мэргэжилтнүүд

Салбар

- Уул уурхайн компаниуд
- Өрсөлдөгч компаниуд
- Ханган нийлүүлэгчид
- Худалдан авагчид
- Салбарын холбоод
- Бизнесийн холбоод
- Бусад

Хууль, хяналтын байгууллагууд

- Сум дахь газар, хэлтэс
- Аймгийн газар, хэлтэс
- Яам, агентлаг, газрууд
- Олон улсын байгууллагууд
- Бусад

Иргэний нийгмийн байгууллагууд

- Орон нутгийн ТББ-ууд
- Үндэсний ТББ-ууд
- Олон улсын ТББ-ууд
- Төслийн үйл ажиллагаа, үйл ажиллагааны төрөл, тухайн орон нутагт сонирхол бүхий олон улсын байгууллагууд
- Бусад

Бусад бүлгүүд

- Хүний эрхийн идэвхтнүүд
- Эрүүл мэнд аюулгүй ажиллагааны бүлгүүд
- Хүний эрхийн бүлгүүд
- Нийгмийн тэгш байдлын бүлгүүд
- Улс төрийн бүлгүүд
- Бусад

Тусгайлан сонирхсон хүмүүс/ бүлгүүд

- Төслийн газар сонирхол бүхий бүлгүүд (бичил уурхайчид)
- Компанийн үйл ажиллагаанд сонирхол бүхий бүлэг (өмнө нь байсан хамтрагчид)
- Салбарын үйл ажиллагаанд сонирхол бүхий бүлгүүд
- Одоо оролцож буй бүлгүүд
- Оролцохыг хүсэж буй бүлгүүд
- Таны оролцохыг хүсэж буй бүлгүүд
- Хэвлэл мэдээлэл
- Бусад

ОЛОН УЛСЫН ТҮВШИНД ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН МАТРИЦ ГАРГАСАН БАЙДАЛ

Оролцогч талууд	Гол асуудлууд	Харилцаа холбооны бэлэн хэрэгслүүд	Харилцаа холбооны илүү үр дүнтэй хэрэгслүүд	Гол агуулга
Зохион байгуулагч	• Үйл ажиллагааны аюулгүй байдал • Эрүүл мэнд, байгаль орчны нөлөөлөл • Тэтгэмжийн багц • Гэнэтийн аюулд бэлэн байдал	• Уулзалт • Илтгэл • Бичмэл харилцаа холбоо	• Ижил төрлийн байгууламжуудад айлчлах • Боловсролын үйл ажиллагаа, үзүүлэн	• Цацраг идэвхт хаягдлын урт хугацааны менежментийн шийдэл • Аюулгүй, хариуцлагатай үйл ажиллагаа • Орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжил
Хэвлэл мэдээлэл	• Олон нийтийн санаа зовнисон асуудлууд • Мэдээ, нийтлэл болгохуйц зүйл мөн үү? • Хэвлэл мэдээллийн нөлөөлөл	• Уулзалт • Семинар • Бичмэл харилцаа холбоо • Нийгмийн сүлжээ	• Хэвлэлийн бага хурал, хэвлэлийн мэдээлэл • Талбайн айлчлал (Хэвлэлийнхэнтэй хийх аялал) • Харилцах холбоос	• Аюулгүй, хариуцлагатай үйл ажиллагаа (олон улсын стандартад нийцсэн) • Үнэн зөв мэдээллийн шууд хүртээмж
Эрх баригч улс төрчид	• Төслийн санхүүжилт • Хууль эрх зүйн албан бичгүүд	• Уулзалт • Бичмэл харилцаа холбоо	• Уулзалт • Лобби хийх	• Цацраг идэвхт хаягдлын урт хугацааны менежментийн шийдэл • Аюулгүй байдалд түрүүлж анхаарах
Иргэний нийгмийн байгууллагууд	• Байгаль орчны асуудлууд • Ил тод байдал байдал • Аюулгүй байдал	• Уулзалт • Семинар • Бичмэл харилцаа холбоо • Нийгмийн сүлжээ	• Нээлттэй нийгэм • Илтгэл, уулзалт • Имейл • Биечлэн уулзах	• Аюулгүй, хариуцлагатай үйл ажиллагаа • Ил тод байдал

Алхам 2. Оролцогч талуудыг тодорхойлохдоо жендерийн тэгш байдлыг харгалзан үзэх хэрэгтэй. Мөн, иргэний бүлэг, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, эмзэг бүлгийн нөлөөллийг тэгш хамруулах шаардлагатай. Оролцогч талуудаа тодорхойлсны дараа (хэсэг “3.2. Олон нийтийн оролцоог хангах үе шатууд” хэсгийн “Мэдээлэл түгээх арга замууд” хүснэгтээс харна уу) мэдээлэл түгээх арга хэлбэрүүдийг ашиглан, мэдээллийг хүртээмжтэй түгээнэ.

3.2. ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦООГ ХАНГАХ ҮЕ ШАТУУД

Манай орны хувьд БОНБУ-ний тайланд олон нийтийн оролцоог хангахдаа урьдчилж олон нийтийн оролцоог хангах төлөвлөгөө боловсруулах эрхзүйн зохицуулалт байхгүй. Олон нийтийн саналыг авахдаа багийн Иргэдийн Нийтийн Хурал (ИНХ) буюу нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагаар дамжуулан хэлэлцүүлдэг зохицуулалт үйлчилж байгаа нь төсөл хэрэгжүүлэгч болон үнэлгээний мэргэжлийн байгууллага тусдаа төлөвлөгөө боловсруулж, иргэдээс санал авах хурал зохион байгуулах боломжийг хязгаарладаг учир дутагдалтай.

“Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах” журмын дагуу байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах ажлыг 2 үе шаттай байх, тус бүрийн арга хэлбэрийг зохицуулсан байдаг. Үүнд:

Алхам 3. Оролцогчдын сонирхол, нөлөөллийг харгалзан үзэж, тэдний дэмжлэгийг авахын тулд юу хийх хэрэгтэйгээ төлөвлөх нь асуудлыг шийдэх боломжийг нэмэгдүүлнэ. Хэн, ямар үндэслэлээр дэмжиж байна, хэн сонирхож байна, хэн ямар шалтгаан, үндэслэлээр дэмжиж, эсэргүүцэж байна вэ гэдгийг тодорхойлсноор оролцогч бүртэй хамтран ажиллах, нөлөөлөх арга замаа мэдэж авна. Мөн хаанаас эхэлж, хэн дээр хамгийн түрүүнд очих нь тодорхой болно.

Үе шат 1 -Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ боловсруулах шатанд хийгдэх уулзалт, асуумж судалгаа

Тус журмын 2.5.2 дахь заалтыг үндэслэн БОННУ боловсруулж буй хийх эрх бүхий аж ахуйн нэгж нь байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний судалгаагаар нөлөөллийг тогтоох, таамаглах, үнэлэх үе шатан дахь олон нийтийн оролцоог хангах шаардлагатай. Ингэхдээ:

- иргэдтэй уулзалт хийх,
- иргэдийг оролцуулан нөлөөллийг үнэлэх аргачлалыг ашиглах,
- уулзалт хэлэлцүүлэг хийх,
- бичгээр санал асуулга явуулах зэрэг арга хэлбэрээр иргэдийн саналыг авна.

Үе шат 2 -Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ боловсруулж дууссаны дараа Иргэдийн нийтийн хурлаар хэлэлцүүлэх

Тус журмын 2.7 дахь заалтыг үндэслэн төсөл хэрэгжүүлэгч болон БОННУ боловсруулж буй хийх эрх бүхий аж ахуйн нэгж хамтран байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан болон байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулж дууссаны дараа үнэлгээний тайлан, үе шат 1-д заасан олон нийтийн саналын нэгдсэн дүнг ажлын 15 өдрийн хугацаанд тухайн нутаг дэвсгэрийн баг, хорооны Иргэдийн нийтийн хурлаар хэлэлцүүлж, санал авах шаардлагатай байдаг.

Үнэлгээний тайлангийн төслийг ИНХ буюу нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагаар хэлэлцүүлдэг зохицуулалт зөвхөн Монгол Улсад хэрэгждэг. Энэ нь үнэлгээний тайланг танилцуулах, иргэдээс санал авах ажлын зохион байгуулалт

тодорхой бус болох, зорилтот үр дүндээ хүрэхгүй байх зэрэг хүндрэлүүдийг үүсгэсээр байна. Судлаачдын онцолж байгаагаар төсөл хэрэгжүүлэгч нь орон нутгийн захиргаатай хамтран үнэлгээний тайланд санал авах хэлэлцүүлэг, сонсголыг хурдан шуурхай зохион байгуулах, олон нийтэд урьдчилж зар мэдээ хүргүүлэх, иргэдэд мэдээлэлтэй танилцаж, уншиж судлах хугацаа олгох арга замаар хэрэгжүүлэх шаардлага гарсаар байна.

Мөн дээр дурдсан санал авах, хэлэлцүүлэг хийх үйл ажиллагааг нотлох баримт бичиг нь БОНБУ-ний хуулийн 8.4.8-д заасанчлан төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн баг, хорооны Иргэдийн нийтийн хурлын хурлын тогтоол, тэмдэглэл юм гэж заасан байдаг. Иймд одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль, журмын хүрээнд байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээнд иргэдээс санал авах үйл ажиллагааг хэрхэн сайжруулж болох тухай аргачилсан зөвлөмжийг хүргэе.

3.3. ОЛОН НИЙТИЙН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ ХИЙХ ШИЙДВЭРИЙГ ГАРГАХ

Алхам 1. Төсөл хэрэгжүүлэгч эсвэл БОННУ боловсруулж буй хийх эрх бүхий аж ахуйн нэгж нь байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан болон байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулж дууссаны дараа үнэлгээний тайланг тухайн баг, хорооны Иргэдийн нийтийн хурлаар хэлэлцүүлэх хүсэлтийг Баг, хорооны Иргэдийн Нийтийн

Хурлын Зөвлөлд хүргүүлнэ.

Алхам 2. Хүсэлтийг хүлээж авсан Иргэдийн Нийтийн Хурлын Зөвлөл нь асуудлыг хурлаараа шийдэж, ажлын 15 өдөрт багтаан Төсөл хэрэгжүүлэгч эсвэл БОННУ боловсруулж буй хийх эрх бүхий аж ахуйн нэгжид ИНХ (ээлжит эсвэл ээлжит бус) зохион байгуулах тухай хариу хүргүүлнэ.

3.3.1. ОЛОН НИЙТЭД ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ ТҮГЭЭХ

“БОНБУ-ний бүхий л үе шатны холбогдох мэдээллийг цаг тухай бүрд иргэдэд ил тод, хүртээмжтэй хэлбэр, арга, агуулгаар хүргэх хэрэгцээ маш их байна” гэж 2021 онд Австрали-Монголын эрдэс баялгийн салбарын хамтын ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд боловсруулсан бодлогын судалгааны тайланд дурджээ. Мөн “Багийн хурлаар хэлэлцэх асуудлыг багийн удирдлага тодорхойлж, түүний дагуу иргэдэд зар мэдээ хүргэдэг байна. Багийн хурлын тов тодорхой болсны дараа үнэлгээ эрхлэгч танилцуулах материал, холбогдох мэдээллийг баг, хорооны удирдлагад явуулдаг ч иргэдэд цааш түгээдэг эсэх нь тодорхой бус. Ихэнх тохиолдолд ИНХ-ын хуралдаанаар хэлэлцэх асуудлыг урьдчилан зарлан мэдэгдэх явдал ховор бөгөөд тухайн хуралдаан болох өдөр нь танилцуулдаг байна” гэж дурджээ.

Үүнээс үзэхэд орон нутгийн удирдлагын зүгээс төслийн эхний шатнаас эхлэн боломжит бүхий л сувгийг ашиглан иргэдэд мэдээлэл хүргэдэг байх хэрэгцээ шаардлага байсаар байна.

Алхам 1. Иргэдийн Нийтийн Хурлын хуралдааны товыг хуралдаан болохоос ажлын 5-аас доошгүй өдрийн өмнө тухайн баг, хорооны оршин суугчдад мэдээлэх бөгөөд хуралдах байршил, цагийг тусгасан байна.

Ингэхдээ, ИНХ-ын зар, хэлэлцэх асуудлыг иргэдэд нээлттэй, хурдан шуурхай хүргэхийн тулд “Нийтийн зар мэдээний журам”-д заасан дараах арга замуудаас боломжит хувилбарыг сонгох


боломжтой юм.

- Зар мэдээг олон сувгаар хүргэх (олон нийтийн үйлчилгээний газар зарлал тараах, гэрлэн самбараар түгээх, зар мэдээлэх узел, зар мэдээг сонирхолтой, тухайн хурлын ач холбогдлыг ойлгуулсан агуулга хэлбэрээр бичиж түгээх
- Иргэдийн мэдээлэл авдаг гол сувгууд буюу телевиз, радио, fm, сонин, нийгмийн сүлжээ (Facebook), цахим хуудас зэргээр мэдээлэл хүргэх,
- Зар мэдээг сонирхолтой, тухайн хурлын ач холбогдлыг иргэдэд ойлгомжтой хэлбэрээр буюу зурагт хуудас, мэдээллийн хуудас байдлаар бэлтгэж хүргэх,
- Аман зар буюу иргэдтэй уулзаж албан ёсоор тайлбарлан таниулах,
- Баг, хороонд бүртгэлтэй иргэдтэй утсаар холбогдох эсвэл мессеж илгээх байдлаар идэвхжүүлэлт хийх.

Алхам 2. Иргэдийн Нийтийн Хурлыг зохион байгуулах, хуралдаанд бэлтгэх, хуралдааныг товлон зарлах, хуралдааны ирцийг хангах ажлыг холбогдох хуульд заасны дагуу баг, хорооны Засаг дарга болон Хуралдааны дарга, хорооны хэсгийн ахлагч хариуцна.

Алхам 3. Шаардлагатай тохиолдолд Иргэдийн Нийтийн Хурлын зар түгээх, иргэдэд байгаль орчны нөлөөллийн үнэлгээтэй холбоотой мэдээлэл өгөх, иргэдийн оролцоог хангахад чиглэсэн арга хэмжээнүүдэд төсөл хэрэгжүүлэгч эсвэл БОННУ боловсруулж буй хийх эрх бүхий аж ахуйн нэгжээс дэмжлэг авч болно.





МЭДЭЭЛЭЛ ТҮГЭЭХ АРГА ЗАМУУД:

	Онцлог	Давуу тал	Сул тал
Хэвлэмэл материалууд	Мэдээллийн самбар, брошур, тайлангууд: • Бичвэрүүд энгийн, техникийн бус, орон нутгийнханд таарсан хэллэгээр, уншигчдад ойлгомжтой байдлаар бичигдсэн байх хэрэгтэй. • Дэлгэрэнгүй мэдээллийг хэрхэн авах талаарх зааварчилгааг ойлгомжтой хүргэх	• Шууд хүрнэ • Мэдээллийг дэлгэрэнгүй хүргэнэ • Зардлын хувьд үр ашигтай • Харилцаа холбооны урт хугацааны бүртгэл, түүх үүсгэнэ	• Мэргэжлийн ур чадвар, нөөц бололцоо шаардлагатай
Үзүүлэн	• Мэдээлэл хүргэх, цуглуулах байдлаар ашиглах боломжтой.	• Урьдчилж тодорхойлоогүй талуудад хүрэх боломжтой • Олон нийтэд хүрэх шаардлага хамгийн бага байна	• Бэлтгэл ажил, ажиллах хүчний зардал нэмэгдэнэ • Техникийн тусламж шаарддаг
Хэвлэмэл хэрэгсэл	• Сонин, хэвлэлийн мэдээлэл, хэвлэлийн бага хурлаар олон төрлийн их хэмжээний мэдээлэл түгээх боломжтой.	• Үндэсний болон орон нутгийн сурвалжлага санал болгоно • Бичиг үсэгт тайлагдсан ихэнх насанд хүрэгчдэд хүрэх боломжтой • Дэлгэрэнгүй мэдээлэл хүргэх боломжтой	• Танилцуулах явцад хяналт алдагдах талтай • Хэвлэл мэдээллийн харилцааны шаардлага өндөр • Бичиг үсэг мэддэггүй хүмүүст хүрэхгүй

	Онцлог	Давуу тал	Сул тал
Хэвлэлийн цахим хэрэгсэл	Телевиз, радио, видео: Сурвалжлагын хамрах хүрээ (үндэсний хэмжээний эсвэл орон нутгийн), үзэгчдийн төрөл, төсөөлж буй зорилтууд, санал болгож буй нэвтрүүлгүүдийг тодорхой болгох.	- Эрх мэдэлтэй гэж ойлгогдох боломжтой. - Ихэнх хүнд радио холбоо хүртээмжтэй	- Олгогдох хугацаа нь хязгаарлагдмал байх магадлалтай - Өндөр өртөгтэй
Сурталчилгаа	- Олон нийтийн уулзалт болон бусад үйл ажиллагаанд хэрэгтэй. - Хүргэх байдал, зорилтот бүлгүүдийг тодорхойлж буй байдлаас үр дүн нь хамаарна.	Хүмүүст хүрэх байдлыг хянах боломжтой	Сэжиг төрүүлэх магадлалтай
Мэдээлэл хүргэх албан хурлууд	Зорилтот хүмүүст хүрэх уулзалт: Төслийг ивээн тэтгэгч эсвэл хүсэлт гаргагч тал тодорхой бүлэг, компани, аж үйлдвэрийн холбоонд зориулж зохион байгуулж болно.	- Тодорхой нэгдмэл асуудалтай бүлгүүдэд үр дүнтэй - Тодорхой асуудлын хүрээнд нарийн хэлэлцүүлэг өрнүүлэх боломжтой.	Бодит бус хүлээлт үүсгэх магадлалтай.
Мэдээлэл хүргэх албан бус хурлууд 	Нээлттэй өдөрлөг, талбайн айлчлал, талбайн оффис: - Сонгосон бүлгүүд мэдээллийг шууд хүлээн авч, төслийн албаныхантай холбоо тогтоох боломжтой. - Дэлгэрэнгүй мэдээлэл бүхий материалууд, эсвэл нэмэлт уулзалт, хэлэлцүүлэг хэрэгтэй.	- Дэлгэрэнгүй мэдээлэл хүргэнэ - Өөр хувилбаруудтай харьцуулахад хэрэгтэй - Шууд хүрнэ - Цогц төслүүдэд хэрэгтэй - Орон нутгийн оршин суугчдын асуудлуудыг албаныханд хүргэнэ. - Оршин суугч бус оролцогч талуудад хүрэх боломжтой	- Хэдий хэмжээний хүн оролцох эсэхийг урьдчилж мэдэхэд хэцүү тул зөвшилцөлд хүрэх боломж хязгаарлагдмал - Ихэнх нь илүү өргөн хүрээний төлөвлөлт шаарддаг - Талбайн оффисуудыг ажиллуулахад өндөр өртөгтэй. - Цөөн хүний бүлэгт л хүрдэг.

3.4. ИРГЭДИЙН НИЙТИЙН ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ

ИНХ-ын үнэлгээний хэлэлцүүлгийг одоогийн жишгээр ээлжит хурлаар хийх үү, ээлжит бус хурал зарлаж хийх үү, үнэлгээний урьдчилсан мэдээллийг хэн, ямар хэлбэрээр, хэзээ иргэдэд хүргэх вэ, орон нутгийн удирдлага, төсөл хэрэгжүүлэгчийн үүрэг хариуцлага ямар байх вэ гэдэг

асуултуудыг хууль, журамд тодорхой тусгаагүйн улмаас иргэдийн оролцоог хангахад бэрхшээл тулгарсаар байна. ИНХ-аар тайлан хэлэлцэх үйл явцыг нээлттэй, үр нөлөөтэй, оролцоотой болгохын тулд талуудын үүрэг оролцоо маш чухал юм.

**Бэлтгэл
ажил
хамгийн
чухал.
Хэлэлцүүлэг
амжилттай
болох нь
үүнээс л
хамаардаг.**

Жишээ:

Журамд төсөл хэрэгжүүлэгч, үнэлгээ эрхлэгч хамтран БОННУ-ний тайлан, олон нийтийн саналын нэгдсэн дүнг ажлын 15 өдрийн хугацаанд баг, хорооны ИНХ-аар хэлэлцүүлж санал авахаар заасан нь амьдралд нийцэлгүй байна. Судалгаанд оролцогчдын мэдээлснээр баг, хороодын хурлын тогтсон хуваарь буюу тов байдаггүй. Жилд дунджаар 2-4 удаа болдог ИНХ-ын хуралдааны товыг хүлээж, хэрэв хуралдааны тов эрт буюу ойрхон зарлагдсан бол 1-3 сард багтаан хэлэлцүүлэгт орох, хэрэв тухайн улиралд амжаагүй эсвэл хуралдаан товлогдохгүй удах тохиолдолд 1-3 сар хүлээх болдог байна.

Эх сурвалж: “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох нь” бодлогын судалгаа, 2021

Хэлэлцүүлгийн бэлтгэл ажлыг хангах

- **Хэлэлцүүлгийн байр:** Аль болох олон хүн оролцох, тэдний тухтай байх боломжийг хангах
- **Хэлэлцүүлгийн материал:** Хэлэлцүүлгийн үеэр мэдээлэх, ярилцах, санал авах, оролцогчдын бүртгэлийн хуудас, шийдвэр гаргах бүхий л бичиг баримт, тайлан, мэдээ зэрэг материалыг бэлтгэж, шаардлагатай бол хэвлэж хувилах
- **Ажил үүргийн хуваарь:** Хэлэлцүүлгийн протоколыг хөтлөх, хэлэлцүүлгийг чиглүүлж удирдах, оролцогчдыг бүртгэх, хэлэлцүүлгийг хэвлэл мэдээллээр дамжуулах г.м үүргийг тодорхой болгож, хуваарилж өгөх
- **Хэлэлцүүлгийн техникийн бэлтгэл:** Хэлэлцүүлгийн үеэр аудио болон видео материал үзүүлж сонсгох, зураг үзүүлэн таниулах материал байрлуулах, фото зураг авах зэрэгт ашиглах техникийн бэлтгэлийг хангах

Байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд санал өгөх хэлэлцүүлгийг үр дүнтэй болгохын тулд хэлэлцэж буй асуудлаа бүрэн ойлгох, тайланд алдаа дутагдал байгаа эсэх, төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн хэмжээнд суурь судалгааг орхигдуулалгүй гүйцэтгэсэн эсэх, байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийг үнэн зөв үнэлж, нөлөөллийг бууруулах арга хэмжээг хангалттай төлөвлөсөн эсэхэд илүүтэй анхаарал хандуулах шаардлагатай.

Хэлэлцүүлгийн хөтөлбөр, дэгийг сайн баримтлах нь хэлэлцүүлгийг үр бүтээлтэй, амжилттай болоход хамгийн чухал нөлөө үзүүлдэг.

Хуралдаан даргалагч нь хурлыг зөв удирдан чиглүүлж, иргэдийг асуудлын хүрээнд асуулт, хариулт, санал хэлэх боломжоор хангаж ажиллах нь зүйтэй. Ингэснээр иргэдийн зүгээс тухайн үнэлгээний тайланд бүтээлчээр санал, зөвлөмжөө тусгуулах, үнэлгээний тайланд орхигдсон асуудлуудыг нэмж тусгуулах, тайлангийн чанар сайжрах, иргэд төрийн шийдвэр гаргалтад өөрсдийн дуу хоолойг бүрэн хүргэх зэрэг давуу талтай.

Үнэлгээний тайланд иргэдээс санал авах ажлын үр дүнг нэмэгдүүлэх үүднээс үнэлгээний тайлан хэлэлцүүлэхэд хурлын дэг, үргэлжлэх хугацаа, хэлэлцүүлгийн зорилго, зорилтыг иргэдэд танилцуулах, иргэдийн саналыг нээлттэй эсвэл хаалттай авах зэрэгт сайжруулалт хийх шаардлага зүй ёсоор байсаар байна. Иймд, хэлэлцүүлгийн үр нөлөөг сайжруулах дараах саналуудыг дэвшүүлж байна.

Үйл ажиллагаа	Сайжруулах арга зам
ИНХ зохион байгуулах дэг	a. ИНХ нь хуралд оролцож буй оролцогчдын бүртгэлийг хийж, гарын үсгээр ирцийг баталгаажуулах, b. ИНХ эхлэхийн өмнө хурал даргалагч хурлаар хэлэлцэх асуудлууд, тэдгээрийн дарааллыг батлуулж, хурлын дэг, ИНХ-ын хуралд оролцогчдын эрх ба үүргийг оролцогчдод товч танилцуулах, c. Хурлын дэгд дараах зүйлс багтвал зохилтой. Үүнд: i. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээнд санал хураахгүй зөвхөн иргэдийн санал, зөвлөмжийг авах, ii. Нэг удаа асуулт, хариулт, санал хэлэх хугацаа 3-5 минут байх, iii. Иргэдийн оролцоог тэгш байлгах үүднээс нэг иргэнээс асуулт, хариулт, санал хэлэх хэмжээг тогтоох, iv. Хуралдаан сунжирч болзошгүй тохиолдолд Хуралдааны дарга санал авах ажиллагааг таслах, v. Хэлэлцэх асуудлын хүрээнд нээлттэй асуулт, хариулт, санал хэлэхийг Хурал даргалагч оролцогчдод сануулах,
Илтгэл, танилцуулга хийх	a. Хурлын хөтөлбөр дээр илтгэл, танилцуулга хийх хугацааг 15-30 минут байлгах, b. Илтгэл, танилцуулгыг хэт нүсэр биш товч тодорхой, энгийн үг хэллэгтэй бэлдэхийг төсөл хэрэгжүүлэгч болон үнэлгээний мэргэжлийн байгууллагад сануулах, c. Хурлын хөтөлбөрийн дагуу илтгэл, танилцуулгыг цагтаа багтаан танилцуулахыг төсөл хэрэгжүүлэгч болон үнэлгээний мэргэжлийн байгууллагад сануулах
Санал авах хэлбэрүүд	a. Иргэдийн саналыг нээлттэй эсвэл хаалттайгаар авч болно, b. Санал авах хэлбэрийн хувьд амаар эсвэл бичгээр авч болно. Хэрэв шаардлагатай бол дээрх аргуудыг хослуулан саналыг авна, c. Хэлэлцүүлэгт иргэд, оролцогч талууд сайн дураар оролцох, санал бодлоо бичгээр илэрхийлэх боломжоор хангах, ингэхдээ хурлын дэгийг баримтлах
БОННУ -ний тайланд санал өгөхтэй холбоотой анхаарах асуудлууд	a. Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн хүрээнд байгаль орчны суурь судалгаа хангалттай хийгдсэн эсэх, b. Төслийн нөлөөллийн бүсийн иргэдтэй уулзалт, ярилцлага, асуумж судалгаа хийсэн эсэх, c. Иргэдээс өмнө өгсөн санал, зөвлөмжийг тайланд тусгасан эсэх, d. Байгаль орчны нөлөөллийг бодитой үнэлсэн эсэх, e. Нөлөөллийг бууруулах арга хэмжээг бодитой төлөвлөж, холбогдох зардлыг тусгасан эсэх
Нэмэлт санал авах боломж	a. Хурлын дараа нэмэлт санал иргэдээс ирвэл төсөл хэрэгжүүлэгч болон үнэлгээний мэргэжлийн байгууллагад хүргүүлж болно, b. Хуралд оролцох боломжгүй иргэдийн оролцоог хангах үүднээс саналыг урьдчилан бичгээр авч болно
Саналыг БОННУ-ний тайланд тусгасан тухай мэдээлэл хүргүүлэх	a. Байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд иргэдийн өгсөн саналуудыг ИНХ-ын тогтоол, тэмдэглэлд тодорхой тусгаж, төсөл хэрэгжүүлэгч болон үнэлгээний мэргэжлийн байгууллагад хүргүүлнэ, b. ИНХ-ын тогтоол, тэмдэглэлд туссан саналуудыг төсөл хэрэгжүүлэгч болон үнэлгээний мэргэжлийн байгууллага Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тайланд тусгаж, саналуудыг хэрхэн тусгасан тухай товч тайланг баг/ хорооны ИНХ-ын зөвлөлд хүргүүлнэ.

ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ҮЕД ГАРЧ БОЛОХ МАРГААН, ЗӨРЧЛӨӨС СЭРГИЙЛЭХ ЗӨВЛӨМЖ

Аливаа хэлэлцүүлэг, хурлын үед гардаг маргаан, зөрчлийг шийдвэрлэх нь зөвшилцөлд хүргэдэг.

Иргэд хэлэлцүүлэгт оролцох гэж ирэхдээ өөрт тулгамдсан асуудлаа, уур бухимдлаа, хийсэн ажил болгоныг шүүмжилдэг зангаа “хамж аваад” ороод ирдэг тал бий. Үүнээс болж зохион байгуулагч, чиглүүлэгч, оролцогчдын дунд зөрчил гардаг. Тиймээс хэлэлцүүлгийг зөв хөтлөн чиглүүлж чадвал иргэдийн уур бухимдал арилж, зөвшилцөлд хүрдэг.

Зөрчил үүсвэл хэлэлцүүлгийг хөтөлж, чиглүүлж байгаа хүн дараах арга хэмжээг авах хэрэгтэй.



Зөрчлийн нөхцөл	Зөрчлийг зохицуулах алхам
• Үгээр идэлцэх • Үндэслэлийн эсрэг үндэслэл • Би илүү мэднэ гэж маргах	• Маргааныг эхэлж сонсох байдлаар аядуу зогсоох • Хэлсэн үгийг нь тодруулж, далд санаа агуулахгүй байхыг сануулах • Маргаж буй хоёр талын тодорхой байр суурийг сонсох • Олон нийтийн эрх ашгийн талаарх асуудал биш тохиолдолд хамтын ашиг сонирхлын талаар хэлэлцүүлэг болж буйг анхааруулж, олонхын санал руу чиглүүлэх
• Маргаж буй хүмүүс биеэ барих чадваргүй болж, маргааныг үргэлжлүүлэх, бие бие рүүгээ давшлах	• Маргааныг шууд таслан зогсоох • Түр завсарлах • Өрөө, байранд агаар оруулах • Тайвшрахыг сануулах
• Оролцогчид дуугарахаа болих • Маргаанаас залхах	• Ойлголцохгүй байгаа асуудлыг дахин ярилцах • Гомдолтой байгаа хүмүүсийн саналыг сонсох, бичгээр авах

Хэлэлцүүлгийн үр дүнг баталгаажуулах үйл явц хэлэлцүүлгийн үед ч тэр, хэлэлцүүлгийн дараа ч үргэлжилдэг.

ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ДАРАА

I. Оролцогчдод талархал илэрхийлэх

Хэлэлцүүлэг дууссаны дараа хамгийн түрүүнд хэлэлцүүлэгт оролцсон иргэддээ, хамтран зохион байгуулсан хүмүүстээ талархал илэрхийлэх

II. Хэлэлцүүлгийн тайлан бичих

Хэлэлцүүлгийн үеэр гарсан саналууд, иргэдийн хэлсэн үг, урилгаар оролцсон хүмүүсийн танилцуулга зэрэг бүх мэдээллийг цэгцэлж, хэлэлцүүлгийн тайландаа хавсаргах хэрэгтэй. Хэлэлцүүлгийн тайланг олон нийтэд хүртээмжтэй байлгах үүднээс журамд заасны дагуу нээлттэй тавих

III. Хэлэлцүүлгээс гарсан санал, зөвлөмжийг ангилж зохих байгууллагад нь уламжлах

Юуны өмнө иргэдийн саналыг төрийн байгууллагад уламжлахын өмнө хэлэлцүүлгийн тэмдэглэлд бичигдсэн

иргэдийн саналуудыг дэмжсэн, эсэргүүцсэн, тайлбар гэх мэтээр ангилах хэрэгтэй. Санал, зөвлөмжийг ангилсны дараа зохих байгууллагад нь явуулаарай. Ингэснээр асуудал хэлэлцүүлсэн байгууллага, албан тушаалтан, ажлын хэсэг хэлэлцүүлгээс гарсан саналуудыг шийдвэртээ тусгах болно.

IV. Хэлэлцүүлэгт оролцсон хүмүүстэй эргэх холбоотой байх

Иргэн бүрийн саналыг шийдвэрт тусгах боломжгүй учраас ямар шалтгаанаар шийдвэрт тусгаагүй тухай тайлбарыг иргэдэд мэдээлэх хэрэгтэй.

- Хурлын тэмдэглэлийг бүрэн төгс, утга агуулгыг нь өөрчлөлгүй хэвээр нь буулгах
- Ажил үүрэг хариуцаж авсан хүний нэр, ажил гүйцэтгэх хугацааг тэмдэглэл дотор тод харагдахуйц тэмдэглэх
- Хурлын тэмдэглэлийг хурлын дараа журамд заасны дагуу тарааж өгөх

ТА МЭДЭХ ҮҮ?

ХЭЛЭЛЦҮҮЛГИЙГ ЧИГЛҮҮЛЭХДЭЭ ДАРААХ ЗҮЙЛИЙГ АНХААРДАГ УУ?

1. Хөтлөгч, чиглүүлэгчийн хувьд тухайн агуулгыг сайн мэддэг байх ёстой юу?

- Хэлэлцүүлгийг чиглүүлж буй хүн нь тухайн мэргэжлийн хүн байх албагүй. Тухайн сэдвийн талаар тодорхой ойлголт, мэдээлэл сайтай байж, хөрвөж чаддаг байхад л болно.

2. Яаж санаагаа товч илэрхийлэх вэ?

- Олны өмнө түгдрэлгүй, биеэ барихгүй, өөртөө итгэлтэй ярихын тулд хэлэлцүүлгийн өмнө дасгал, сургуулилалт хийх
- Эхлээд гол санаануудаа гаргаж хэлэх
- Ярихаасаа өмнө санаагаа бичих, сунжруулан тайлбарлахын оронд дүрсжүүлсэн текстийг тод дуугаар уншиж өгөх

3. Ямар бичиг баримтыг урьдчилан болон хэлэлцүүлгийн үеэр бэлтгэх вэ?

- Хөтөлбөр, танилцуулга, тайлан гээд шаардлагатай бүхий л мэдээллийг тараах
- Иргэдийн саналыг авах хуудас, тухайн сэдэвтэй холбоотой асуултад хариулт авах зэрэг хуудсыг хэлэлцүүлгийн үед тараана

4. Иргэдийн анхаарал суларч, тухайн сэдвийн талаар сонирхохгүй байх тохиолдолд юу хийх вэ?

- Хуулийн төсөл болон иргэдэд тэр бүр шууд хамааралтай биш асуудлаар хэлэлцүүлэг хийх үед

иргэдийн сонирхлыг татахын тулд мэдээллээ видео бичлэгээр үзүүлэх, зургаар илэрхийлэх, тухайн асуудлаар бодит жишээ, түүх ярих зэрэг аргыг ашиглах нь үр дүнтэй байдаг.

5. Зарим оролцогчид урьдчилан хөтөлбөр, танилцуулга, бусад материалтай танилцаагүй нөхцөлд хэлэлцүүлгийг хэрхэн үр өгөөжтэй чиглүүлэх вэ?

- Хэлэлцүүлгийн цагт бага зэргийн өөрчлөлт хийх
- Иргэдэд материалыг унших цаг гаргаж өгөөд, иргэдийг уншиж дууссаны дараа бүрэн мэдээлэл авсан эсэхийг тодруулж асуух

6. Хэт их түрэмгийлэн ганцаараа ярих дуртай хүмүүстэй хэрхэн харьцах вэ?

- Хэлэлцүүлгийн өмнө журмыг танилцуулах, хэлэх үгийн цагийн хязгаарыг тодорхой хэлж өгөх, цаасан дээр бичиж хананд байрлуулах
- “Үнэтэй санал хэлсэн танд баярлалаа. Одоо бусад хүмүүс ямар саналтай байгааг сонсьё” гэх мэтээр яриаг зогсоох

7. Иргэд тодорхой шийдвэр гаргахыг хүлээх, шаардах нөхцөлд асуудлыг хэрхэн зохицуулах вэ?

- Завсарлага авч, тухайн сэдвийг түр орхих, өөр асуудлыг хэлэлцэх
- Та шийдвэр гаргагч биш, хөтлөгч учраас шийдвэр гаргах албаны хүнд чиглүүлэгчийн үүргийг хүлээлгэх. Хэрвээ шийдвэр гаргагч нар байхгүй тохиолдолд шийдвэр гаргах асуудлыг хойшлуулан дараагийн хэлэлцүүлгийн үеэр дахин ярилцах хэрэгтэй.



3.4.1. БОННУ-НИЙ ТАЙЛАНГ ОЛОН НИЙТЭД НЭЭЛТТЭЙ БОЛГОХ

ИНХ-аар хэлэлцүүлэхээс өмнөх үе шатны мэдээлэл өгөх, санал авах ажил орхигдох, улмаар ИНХ-аар хэлэлцүүлж, санал авах үйл ажиллагаа нь бодит мэдээлэлд суурилсан байж чадахгүй байна” гэсэн дүгнэлтийг 2021 онд хийсэн “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох нь” бодлогын судалгаагаар гаргажээ.

Тэгвэл иргэдийг мэдээллээр хангахад чиглэсэн үйл ажиллагааг олон улсын туршлагад суурилан хэрхэн хэрэгжүүлж болох тухай дараах саналуудыг толилуулж байна. Үүнд:

Алхам 1. ИНХ зохион байгуулах шийдвэр гаргасны дараа, хурлын зар түгээх үед тухайн хэлэлцэх гэж буй үнэлгээний тайлан, түүний техникийн бус хураангуйн хамтаар баг, хорооны

байр эсвэл сумын тамгын газарт эсвэл төсөл хэрэгжүүлэгчийн цахим хуудсанд иргэдэд нээлттэйгээр байрлуулж танилцах боломжоор хангах,

Алхам 2. Үнэлгээний тайлантай танилцсан иргэдийг чөлөөтэй саналаа өгөх боломжоор хангаж, санал авах хуудас, эсвэл саналын дэвтрийг тайлантай хамтаар байрлуулах,

Алхам 3. Иргэдээс бичгээр өгсөн саналуудыг ИНХ болох өдөр бүртгэн, төсөл хэрэгжүүлэгч эсвэл үнэлгээний мэргэжлийн байгууллагад хүлээлгэн өгөх.

Алхам 4. БОННУ-ний тайлан БОАЖЯ-ны дэргэдэх Мэргэжлийн зөвлөлөөр батлагдмагц, үнэлгээний мэргэжлийн байгууллага сумын Засаг даргын тамгын газарт хүргүүлэх ба сумын Засаг дарга олон нийтэд нээлттэй байлгах үүрэгтэй.

ТА МЭДЭХ ҮҮ?

ОЛОН УЛСЫН ТУРШЛАГААС

БНХАУ-Д ХУУЛИАР ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦООГ ХЭРХЭН ХАНГАЖ БУЙ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

• БОННУ-ний тайлангийн төсөл боловсруулж дууссаны дараа:

Төсөл хэрэгжүүлэгч дараах мэдээллийг олон нийтэд мэдээлнэ:

1. Үнэлгээний тайлангийн төсөлтэй хаанаас танилцаж болох тухай
2. Саналаа хэнд хүргүүлэх тухай
3. Саналын хуудас татаж авах хаяг
4. Бичгээр саналаа хэрхэн гаргах тухай
5. Бичгээр саналаа хэзээ гаргах тухай /Ажлын 10-аас цөөнгүй өдрийн хугацаанд олон нийт санал гаргах боломжтой байна.

Хэрэв нөлөөллийн талаар олон тооны асуулт, сөрөг саналууд гарсан бол олон нийтийн хэлэлцүүлэг, сонсгол, хурал зэрэг илүү гүнзгий зөвлөлдөх арга хэмжээг төсөл хэрэгжүүлэгч зохион байгуулах ёстой. Хэлэлцүүлэг, сонсголыг 10-аас цөөнгүй өдрийн өмнө зарлан мэдээлж хэлэлцүүлэг, сонсголд оролцох сонирхлоо илэрхийлсэн хүмүүсийг бүртгэх, оролцуулах шаардлагатай хүмүүсийг урих ёстой. Хэлэлцүүлэг, сонсголыг дууссанаас хойш 5 өдөрт багтаан хурлын тэмдэглэлийг бэлтгэж, олон нийтэд цахимаар ил тод болгох ёстой. Хэлэлцүүлэг, сонсголыг зохион байгуулахдаа холбогдох орон нутгийн захиргааны байгууллагаас зөвлөмж, дэмжлэг авч болно.

• Төсөл хэрэгжүүлэгч олон нийтийн гаргасан саналыг анхааралтай шинжлэн үзэж, дараах агуулгын хүрээнд тайлан мэдээлэл бэлтгэнэ. Үүнд:

1. Олон нийтийн оролцоог хангах үйл явц, цар хүрээ, авсан арга хэмжээ
2. Саналуудыг хэрхэн цуглуулж, дүн шинжилгээ хийсэн тухай
3. Олон нийтийн саналын дагуу авсан арга хэмжээ, хариу тайлбар

Төсөл хэрэгжүүлэгч нь БОННУ-ний тайлангийн төслийг төрийн эрх бүхий байгууллагад хүргүүлэхийн өмнө түүнийг бүрэн эхээр нь, олон нийтийн оролцооны тайлан мэдээллийн хамтаар өөрийн цахим хуудаснаа нээлттэй байршуулна.

• Холбогдох эрх бүхий байгууллага БОННУ-ний тайлангийн төсөл, олон нийтийн оролцооны тайлан мэдээллийг хүлээн авсны дараа

Холбогдох эрх бүхий байгууллага БОННУ-ний тайланг хүлээн авсны дараа дараах мэдээллийг өөрийн цахим хуудаснаа нээлттэй байршуулна. Үүнд:

1. БОННУ-ний тайлан бүрэн эхээрээ
 2. Олон нийтийн оролцооны тайлан мэдээлэл
 3. Олон нийт саналаа хэрхэн гаргах тухай
- Эрх бүхий байгууллага уг мэдээллийг ажлын 10-аас цөөнгүй өдрийн хугацаанд нээлттэй байлгана.





БҮЛЭГ 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭ БА МЭДЭХ ЭРХ

Монгол Улсын Их Хурлаас 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр “Иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийнхээ хүрээнд газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль

орчинд үзүүлэх нөлөөллийн талаар мэдэх эрхтэй” гэж өөрчлөн найруулснаар Байгаль орчныг хамгаалах тухай болон Байгаль орчинд нөлөөлөх байдлын тухай хуулиудад нэмэлт өөрчлөлт хийх шаардлага тулгарсан.¹²

4.1.1 БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬ

4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт:

• Тухайн нутаг дэвсгэрийн хүрээнд газрын хэвлийн баялгийн ашиглалтын нөхцөл байдал, байгаль орчинд үзүүлж байгаа нөлөөлөл, нөхөн сэргээлт болон эрх бүхий байгууллагаас хяналтын чиглэлээр хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар мэдэх.”

16 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 11 дэх заалт:

• Харьяа нутаг дэвсгэрийн хүрээнд газрын хэвлийн баялгийн ашиглалтын нөхцөл байдал, байгаль орчинд үзүүлж байгаа нөлөөлөл, нөхөн сэргээлт болон хяналтын чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар иргэдэд нээлттэй мэдээлэх, байгаль орчны төлөв байдлын мэдээлэлд тусгаж, Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнах.”


¹²Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсан судалгааны тайлан, 2021 он.



17 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 11 дэх заалт:

- Харьяа нутаг дэвсгэрийн хүрээнд газрын хэвлийн баялгийн ашиглалтын нөхцөл байдал, байгаль орчинд үзүүлж байгаа нөлөөлөл, нөхөн сэргээлт болон хяналтын чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар иргэдэд нээлттэй мэдээлэх, газрын хэвлийн баялгийн ашиглалтын талаар байгаль орчны төлөв байдлын мэдээлэлд тусгаж, Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнах.”

**4.1.2 БАЙГАЛЬ
ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ
БАЙДЛЫН ТУХАЙ
ХУУЛЬ**





18 дугаар зүйлийн 18.5, 18.6, 18.7 дахь заалт:

•**“18.5.** Иргэн тухайн нутаг дэвсгэрийн хүрээнд газрын хэвлийн баялгийн ашиглалтын нөхцөл байдал, байгаль орчинд үзүүлж байгаа нөлөөлөл, нөхөн сэргээлт болон төрийн эрх бүхий байгууллагаас хяналтын чиглэлээр хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар мэдээлэл авах хүсэлтийг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргад гаргана.

•**18.6.** Засаг дарга иргэний энэ хуулийн 18.5-д заасан хүсэлтийн дагуу холбогдох мэдээллийг Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 14.8-д заасан хугацаанд гаргаж өгөх үүрэгтэй.

• **18.7.** Иргэн үйл ажиллагаатай нь холбогдуулан газрын хэвлийн баялгийн ашиглалтын нөхцөл байдал, байгаль орчинд үзүүлж байгаа нөлөөлөл, нөхөн сэргээлтийн талаарх мэдээлэл авах, танилцах боломж олгох хүсэлтийг төсөл хэрэгжүүлэгчид гаргаж болно.”

14 дүгээр зүйлийн 14.1.4 дэх заалт:

• “Иргэний хүсэлтийн дагуу өөрийн үйл ажиллагаатай холбоотой газрын хэвлийн баялгийн ашиглалтын нөхцөл байдал, байгаль орчинд үзүүлж байгаа нөлөөлөл, нөхөн сэргээлтийн явц, үр дүнгийн талаарх мэдээлэл өгөх, эсхүл танилцах боломжоор хангах үүрэгтэй.”

4.1.3 НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬ:

8 дугаар зүйлийн холбогдох заалтууд:

- **8.6.9.** Хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээний явцад байгаль орчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл, үр дагавар, тэдгээрийг арилгах арга хэмжээг тогтоосон байгаль орчны нөлөөллийн үнэлгээний талаарх мэдээлэл, газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн мэдээлэл;
- **8.6.10.** Мэдээлэл хариуцагчийн явуулж байгаа үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, ашиглаж байгаа техник, технологийн хүн, мал, амьтны эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх буюу үзүүлж байгаа нөлөөллийн талаарх мэдээлэл;
- **8.6.13.** Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар нутгийн захиргааны байгууллагаас тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан гэрээ;
- **8.7.** Энэ хуулийн ...”8.4.25, 8.6.7-д заасан мэдээллийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, энэ хуулийн 8.6.9, 8.6.12-т заасан мэдээллийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага”...” тус тус хариуцан нээлттэй, ил тод байлгана”.



Монгол Улсын Үндсэн хуулиар иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийнхээ хүрээнд газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар мэдэх эрхтэй. Уг зохицуулалтын хүрээнд иргэд дараах мэдээллүүдийг холбогдох төрийн болон хувийн байгууллагаас шаардах, гаргуулж авах эрхийг эдэлнэ. **Үүнд:**

- i.** Газрын хэвлийн баялгийн ашиглалтын нөхцөл байдал,
- ii.** Газрын хэвлийн баялгийн ашиглалтын байгаль орчинд үзүүлж буй нөлөөлөл,
- iii.** Газрын нөхөн сэргээлт,
- iv.** Хууль, хяналтын чиглэлээр хэрэгжүүлж буй арга хэмжээ.


Дээрх мэдээллийг авах хүсэлтийг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргад гаргана. Засаг дарга мэдээллийг хүсэлт гаргасан иргэн, хуулийн этгээдэд ажлын 7 өдрийн дотор өгөх бөгөөд хүсэлтийг иргэд хамтран гаргасан бол тэдгээрийн төлөөлөл болох нэг иргэнд мэдээллийг өгнө.

Хэрэв шаардлагатай бол иргэн үйл ажиллагаатай нь холбоотой газрын хэвлийн баялгийн ашиглалтын нөхцөл байдал, байгаль орчинд үзүүлж байгаа нөлөөлөл, нөхөн сэргээлтийн талаар мэдээлэл авах, танилцах боломж олгох хүсэлтийг төсөл хэрэгжүүлэгчид шууд гаргаж болно. Аж ахуйн нэгжүүд иргэдийг мэдээлэл авах, эсхүл үйл ажиллагаатай танилцах боломжоор хангах үүрэгтэй.

БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛӨЛТЭЙ ХОЛБООТОЙ МЭДЭЭЛЛИЙН ЭХ ҮҮСВЭРҮҮД

Монгол Улсын байгаль орчин болон уул уурхайн салбар, төслийн байгаль орчны нөлөөлөлтэй холбоотой мэдээллийн эх үүсвэрийг дараах хүснэгтэд нэгтгэн харуулав.

	Мэдээллийн тайлбар	Мэдээллийн эх үүсвэр
1	Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем	https://legalinfo.mn/mn
2	Байгаль орчны мэдээллийн сан	https://eic.mn/
3	Байгаль орчны эрх зүйн мэдээллийн сан	https://eic.mn/legalinfo/
4	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх эрх бүхий мэргэжлийн байгууллагын жагсаалт	https://www.eic.mn/eia/orgpermission.php
5	Батлагдсан байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээний дүгнэлт	https://www.eic.mn/eia/generalreport.php
6	Батлагдсан байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан	https://www.eic.mn/eia/eiareport.php
7	Батлагдсан хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний тайлан	https://www.eic.mn/eia/impactreport.php
8	БОННУ хийгдсэн төслийн газарзүйн мэдээлэл	https://www.eic.mn/eia/gis.php
9	Эрдэс баялгийн боловсролын мэдээллийн сан	http://edu.mrpam.gov.mn/
10	Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга (ОУИТБС)-ын цахим тайлангийн систем	https://e-reporting.eitimongolia.mn/
11	Уул уурхайн компьютерын кадастрын систем (УУККС)	https://cmcs.mrpam.gov.mn/cmcs
12	Уул уурхайн ашиглалт, хайгуулын мэдээллийн сан	https://eic.mn/mining/
13	Эвдэрсэн газрын мэдээллийн сан	https://eic.mn/dlid/
14	Байгаль орчны холбогдолтой гэмт хэрэг зөрчлийн мэдээллийн сан	https://eic.mn/offence/
15	Ой, ус, тусгай хамгаалалттай газрын кадастрын лавлагааны мэдээллийн сан	https://eic.mn/cadastre/cadastreinfo.php





5.ХАВСРАЛТУУД

5.1 МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАХ, ХЯНАХ, ҮНЭЛЭХ АРГУУД



Байгаль орчинд үзүүлж болзошгүй нөлөөллийн талаар иргэдээс мэдээлэл авах, тэдний мэдэх эрхийг хангах асуудлыг төрийн бүх шатны байгууллага хэрэгжүүлэх үүрэгтэй. Мөн байгаль орчны үнэлгээний талаар хяналт үнэлгээ хийхэд хэрэгтэй хамгийн чухал

мэдээллүүдийг оролцоонд суурилсан судалгааны аргуудыг ашиглан олж авах шаардлага гардаг. Тиймээс мэдээлэл цуглуулах, хяналт, үнэлгээ хийхэд ашигладаг дараах аргуудыг хавсаргав.

Аргууд	Тайлбар	Давуу тал	Сул тал
1. Ярилцлага	Энэ ярилцлагын үеэр төсөлд хамрагдагсдаас шалгуур үзүүлэлтийн талаар мэдээлэл авахад чиглэсэн тусгайлан бэлтгэсэн асуултуудыг ашиглана. Асуултууд нь хаалттай буюу (“тийм”, “үгүй” гэсэн хариулттай) нээлттэй байж болно. Чанарын ба тоон мэдээллийг цуглуулах боломжтой.	Ярилцлагыг төсөлд оролцож буй хүн бүртэй хийж болно. Ярилцлагыг нүүр тулж, эсвэл утсаар, емайлаар хийж болно. Ерөнхийдөө уян хатан гэсэн үг.	Ярилцлагыг хөтөлж буй хүнээс ур чадвар шаарддаг.
2. Гол мэдээлэгчтэй хийх ярилцлага	Гол мэдээлэгч нь тодорхой асуудлаар мэргэшсэн хүмүүс байх буюу тухайн асуудлаар илүү мэдээлэлтэй хүнийг хэлнэ.	Гол мэдээлэл өгч буй хүн нь ихэвчлэн төсөлд хамрагдаагүй хүмүүс байдаг учраас асуудалд бодитой ханддаг. Тийм учраас тэд асуудлыг төсөлд хамрагдсан хүмүүсийг бодвол илүү өргөн хүрээтэй хардаг.	Ярилцлага хөтөлж байгаа хүн нь судалж буй асуудлаа нэлээд сайн мэддэг, ярилцлага хөтлөх ур чадвартай хүн байх хэрэгтэй. Гол мэдээлэгчийн хэлснийг маргаангүй үнэн гэж хүлээн зөвшөөрөхгүй байхад анхаарах ёстой.
3. Асуулга	Тусгайлан бэлтгэсэн асуултын дагуу санал асуулга бэлтгэж хүмүүсээс бичгээр хариулт авна. Хариултуудад үндэслэн дүн шинжилгээ хийж, дүгнэлт гаргадаг.	Цаг хэмнэх, олон хүнд хүрэх давуу талтай. Хүмүүс нэрээ бичих шаардлагагүй учраас асуултуудад илэн далангүй хариулах боломжтой.	Бичиг үсэг мэдэхгүй хүмүүсээр бөглүүлэх тохиолдолд уншиж өгөх хэрэгтэй болдог учраас цаг их авдаг. Асуулгыг хэрэглэхэд хариултуудын талаар дэлгэрэнгүй мэдээлэл авах боломжгүй байдаг тал бий. Мөн асуулгыг их хэрэглэдэг учраас хүмүүс залхдаг талтай. Асуулгыг урьдчилан хүмүүс ойлгож байгаа эсэхийг мэдэхийн тулд турших шаардлага гардаг.
4. Орон нутгийн ажилтны тайлан	Тусгай бүтэцтэй тайлангийн маягтад үзүүлэлтүүдтэй холбоотой асуултуудыг оруулна.	Уян хатан, их цаг шаардахгүй, хямд төсөр. Хэвийн үйл ажиллагааны нэг хэсэг юм.	Ажилтны тогтмол үйл ажиллагаанаас шалтгаална.



Аргууд	Тайлбар	Давуу тал	Сул тал
5. Фокус бүлгийн ярилцлага	Тусгайлан бэлтгэсэн асуултуудын дагуу 7-12 хүнийг ур чадвар бүхий хөтлөгч чиглүүлж ярилцлагыг өрнүүлнэ. Асуултууд нь ихэнхдээ ямар нэгэн асуудлыг судлахад чиглэгдэнэ.	Энэ аргаар янз бүрийн үзэл бодолтой хүмүүсээс тодорхой асуудлаар нарийвчилсан мэдээллийг авах боломжтой.	Фокус бүлэгт орох хүмүүсийг сонгоход хэцүү. Гарсан дүгнэлтийг нийтийн санал гэж хамааруулж ойлгож болохгүй. Ярилцлагын үед хүмүүс бие биедээ үзэл бодлын хувьд нөлөөлж болно.
6. Үзүүлэн материал ашиглах	Зураг, дүрс бичлэг, фото зураг, дуу бичлэгийн хуурцаг, дүрд тоглох, түүх бичих зэргийг асуудал, үйл явдлыг тайлбарлах, үзүүлэхэд ашиглана.	Бусад аргатай хосолж ашиглаж болно. Олон хүнтэй, мэдлэгийн түвшин нь янз бүр хүмүүст хэрэглэж болно.	Материалуудыг урьдчилан сайн бэлтгэх хэрэгтэй
7. Оноо өгөх	Энэ аргыг асуудалд хандах хандлага, хүмүүсийн байр суурийг илэрхийлэхэд ашиглана	Хандлага, үзэл бодол, ойлголтыг мэдэхийн тулд хэрэглэж болно.	Асуултыг энгийн бөгөөд маш тодорхой бичих хэрэгтэй.
8. Үйл ажиллагаанд оролцож ажиглах	Арга хэмжээ, үйл явц, хүмүүсийн хоорондын харилцаа, зан үйлийг үйл ажиллагаанд өөрөө оролцож ажиглана	Асуудлыг тодруулах, шалтгааныг ойлгоход хэрэгтэй арга.	Өөрөө оролцохын зэрэгцээ ажиглахад хүндрэлтэй байдаг. Цаг хугацаа их шаардана.
9. Нийгэм, хамт олонтой хийх уулзалтууд	Төслийн үр шимийг хүртэгсдийг цуглуулж тэдэнтэй шийдвэрлэх асуудал, нөхцөл байдлын талаар ярилцаж мэдээллийг цуглуулна.	Тодорхой асуудлаар хэрэгцээтэй мэдээллийг олон тооны хүмүүсээс авах боломжтой. Хүмүүсийг өөрсдийг нь хяналт, үнэлгээний үйл ажиллагаанд оролцуулснаар тэд төсөлд өөриймсгөөр ханддаг.	Чиглүүлэхэд нэлээд туршлага, ур чадвар шаардана. Жижиг бүлгээр ажиллаж, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж болно.
10. Зураг зуруулах	Ямар нэг асуудлаар оролцогчид өөрсдийн мэдрэмжийг илэрхийлэхийн тулд зургаар үзүүлнэ.	Газрын зураг гаргах, бэрхшээлийн мод, нийгмийн бүтцийн зураглал зурах г.м аргуудыг ашиглан бүлгээр ажиллаж болдог.	Заавар өгөх, тайлбар хийхэд хүндрэлтэй байж болно.



5.2 ШАЛГАХ ХУУДАС: ИНХ-ЫН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Та бүхэн дараах хүснэгтэд байгаа асуултын дагуу “тийм” эсвэл “үгүй” гэсэн хариултыг сонгож “✓” тэмдэглэгээ хийнэ үү. Мөн танд нэмэлт санал байвал “Тайлбар” гэсэн хэсэгт бичиж болно.

ИНХ-даа оролцсон танд баярлалаа.

	Асуулт	Тийм	Үгүй
ИНХ-ын өмнө			
1.	ИНХ-ын талаарх зарыг хурал болохоос өмнө авсан уу?		
2.	ИНХ-аар ямар асуудал хэлэлцэх талаар зар дээр тодорхой тусгасан байсан уу?		
3.	ИНХ болох тухай мэдээллийг хаанаас авсан бэ?		
ИНХ-ын үед			
4.	ИНХ-ын зорилго буюу БОННУ-ний тайланд таны оролцоо чухал болохыг тайлбарласан уу?		
5.	ИНХ-аар хэлэлцэх асуудал буюу хэлэлцүүлгийн хөтөлбөрийг тодорхой танилцуулсан уу?		
6.	ИНХ-д оролцогч иргэн таны хуралд хэрхэн оролцох эрх, үүргийг тань тодорхой хэлж өгсөн үү?		
7.	Хурал даргалагч хөтөлбөрийн дагуу хэлэлцүүлгийг чиглүүлсэн үү?		
8.	БОННУ-нд оролцогч талуудаас төлөөлөл хуралд суусан уу?		
9.	БОННУ-ний тайлангийн талаар товч мэдээлэл өгсөн үү?		
10.	БОННУ-ний тайлантай холбоотой иргэдийн асуултад тодорхой хариулсан уу?		
11.	БОННУ-ний тайлантай холбоотой таны саналыг авсан уу?		
12.	Үг хэлсэн хүн бүрийн санал бодлыг тэмдэглэж байсан уу?		
13.	ИНХ-ын үр дүнг нэгтгэж бүх хүмүүст танилцуулсан уу?		
Тайлбар:			



5.3 ШАЛГАХ ХУУДАС: БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Иргэн та дараах асуултын дагуу байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тайланг үнэлнэ үү.

1. Төслийн байгаль орчинд үзүүлэх эерэг ба сөрөг нөлөөг сайн тодорхойлсон байна уу?

☐ Тийм

☐ Үгүй

2. Төслийн байгаль орчинд үзүүлэх эерэг ба сөрөг нөлөө юу байна вэ? Та өөрийн бодлоо хоосон зайнд бичнэ үү.

.....

.....

.....

Төслийн санал нь байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах арга замыг тусгасан байна уу?

☐ Тийм

☐ Үгүй

Байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар тодорхой зүйл тусгаагүй ч гэсэн асуудал үүсвэл урьдчилан сэргийлэх талаар баримтлах арга замыг тодорхойлсон байна уу?

☐ Тийм

☐ Үгүй

Байгаль орчны нөлөөллийн үнэлгээг иргэдээс санал авч үнэн зөв мэдээлэлд тулгуурлан гүйцэтгэсэн байна уу?

☐ Тийм

☐ Үгүй

Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тайланд уулзалт, ярилцлага хийж буйг фото зураг, дүрс бичлэг зэргийг оруулж баримтжуулсан байна уу?

☐ Тийм

☐ Үгүй

Төсөл нь байгаль орчны тогтвортой хөгжилд эерэг хувь нэмэр оруулах магадлалтай байна уу?

☐ Тийм

☐ Үгүй

Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тайланд дараах зүйлүүдийг тусгасан байна уу? Үүнд: үнэлгээг хэн хэзээ хийсэн, харилцах хаяг, утас, үнэлгээнд оролцсон байгууллага, иргэдийн талаарх мэдээлэл г.м

☐ Тийм

☐ Үгүй

Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тайлан ойлгомжтой, тодорхой байсан уу?

☐ Тийм

☐ Үгүй

Танд баярлалаа.

